

АЛСЫН ХАРАА

2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

БҮС, ОРОН НУТГИЙН
ХӨГЖИЛ

8

ᠠᠯᠤᠰᠢᠨ ᠬᠠᠷᠠᠭ᠎ᠠ
ᠲᠣᠮᠤᠯᠤᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠤᠰ

ᠪᠦᠰ, ᠣᠷᠤᠨ ᠨᠤᠲᠦᠭᠢᠨ
ᠬᠡᠭᠭᠢᠯᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭ᠎ᠠ



АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО



БҮС, ОРОН НУТГИЙН
ХӨГЖИЛ

8

Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.



АЛСЫН ХАРАА
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Ерөнхий редактор:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Баянгэрэлийн БАТБААТАР

Редакцын баг:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Сундуйн СОДБААТАР
Өлзийбүрэнгийн ЖАМТЯН
Ганбаатарын ОТГОНЖАРГАЛ

Зөвлөх:

Норжмоогийн ТОГТОХ
Равсалын РИНЧИНБАЗАР
Бямбын ПҮРЭВ
Маширын ЭРДЭНЭБАЯР
Лувсанжанцангийн ЭРДЭНЭБАЯР
Даваасамбуугийн ЭРДЭНЭБАЯР
Хишигбаярын ЭРДЭНЭБУЛГАН
ДамбийнСмын МӨНХЖАРГАЛ
Доржхорлоогийн МӨНХСАЙХАН

Туслан гүйцэтгэсэн:

Цэдэндамбын МЯДАГМАА

Дизайнер:

Нямжавын БЯМБАЦОГТ
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

Хавтасны зураг:

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Гэрэл зураг:

МРА.МН
Жамбалын БАТБААТАР (Баку)
Хишигтогтохын ТҮШИГ

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



ГАРЧИГ

БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	8
ДЭД БҮТЭЦ	32
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	42
ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ	50

Аливаа улсын төрийн бодлогын үндсэн чиглэл нь газар нутгийн өнцөг булан бүрд оршин суух иргэдийнхээ ахуй амьдралын таатай орчныг бүрдүүлэх асуудал бөгөөд эдийн засгийн орон зайн зохион байгуулалт буюу нутаг дэвсгэрээ бүсчлэн хөгжүүлэх нь үүнийг шийдвэрлэх гол арга хэрэгсэл байсаар иржээ.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 9 дүгээр тогтоолоор "Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл", мөн оны 57 дугаар тогтоолоор "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал" батлагдаж, Засгийн газраас уг үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн билээ. Бүсчилсэн хөгжлийн бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлтийн төвүүд болон таталцлын тэнхлэгүүд, кластерыг бий болгох, эко системд түшиглэсэн байгаль орчин, эдийн засгийн хамтын менежментийг хөгжүүлэх, хүн амын эрэлт хэрэгцээ, байгаль орчны нөхцөл, нөөц, даацад нийцсэн эдийн засгийн оновчтой бүтцийг бий болгох, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхээр зорьсон.

Гэсэн ч Монгол Улсын газар нутгийн 0.4 хувийг эзэлдэг Улаанбаатар хотод нийт хүн амын 47.6 хувь суурьшиж, ДНБ-ий 66.2 хувийг бүрдүүлж байгаа нь бүс нутгийн хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтийг эргэн дүгнэх, бүс, орон нутгийг эдийн засгийн нөөцөд нь суурилан тухайн газар нутгийн онцлог, дэд бүтцийн тэнхлэгүүдэд тулгуурлан хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Иймд өөрийн орны хөгжлийн онцлогт тулгуурлан бүс, орон нутгийн хөгжлийг ойролцоо түвшинд хүргэх, хүн амын хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших, эрүүл мэндээ хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд харьцангуй жигд хангах зорилго дэвшүүлсэн.



БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

Монгол хүн эх орныхоо нутаг дэвсгэрийн хаана ч оршин суух, сайхан амьдрах нөхцөлөөр хангагдах ёстой. Орон нутгийг нөөц боломж давуу тал, газарзүйн онцлог, байрлал, байгалийн өгөгдөлд нь тулгуурлан, дэд бүтцэд суурилан хөгжүүлэх нь бүсчилсэн хөгжлийн бодлогын суурь үзэл баримтлал юм. Харин тухайн бүсийн төрөлжилт, дагналт болон бусад бүсүүдийн хоршилтоор кластер хэлбэрээр хөгжих нь бүс нутгийн хөгжлийн гол үндэс болно.

Монгол Улсын иргэн улс орныхоо хаана оршин сууж амьдардаг, ямар ажил эрхэлдэг, нийгмийн гарал байдал, үндэс угсаа, нутаг дэвсгэрийн хол ойр, эдийн засгийн чадавхаас үл хамааран төрийн үйлчилгээг эрх тэгш хүртэх Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй. Зөвхөн төрийн үйлчилгээ төдийгүй ажиллаж амьдрах нөхцөл, хөгжин дэвжих боломжоор хангагдсан байх учиртай.

Улс орны болон орон нутгийн хөгжилд эдийн засгийн үүрэг нэмэгдэх болсонтой уялдан хөгжлийн үзэл баримтлалд дэд бүтцэд суурилан бүсчлэн хөгжүүлэх, бүсчлэх, эдийн засгийн кластер үүсгэх зэрэг онол, үзэл санаа түлхүү хэрэглэгдэж байна. Энэ нь тухайн бүс нутаг жам ёсны давуу талаа түшиглэн хөгжих стратегийн үзэл санаа бөгөөд газар нутгийн хатуу хуваарьт бүсчлэл бус, дэд бүтцийн тэнхлэгүүдэд суурилсан эдийн засгийн бүсчлэл гэдгийг анхаарах нь зүйтэй.

Бүсчлэх гэдэг нь нутаг дэвсгэрийг системчлэн ангилах, түүнд нөлөөлөх, чиглүүлэх арга хэрэгсэл, засаг захиргааны нэгжүүдийн нөөц, боломжийг нийтлэг эрх ашигт нийцүүлэн үр дүнтэй ашиглах, харилцаа, хамтын ажиллагааг нь уялдуулж, зохицуулах, дангаараа шийдвэрлэх боломжгүй асуудалд хамтран шийдэх боломж олгох, улмаар үндэсний хэмжээнд орон зайн нэгдсэн төлөвлөлт, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагаа юм.

Түүхэндээ монголчуудын язгуур нутаг Төв, Баруун, Зүүн түмэн гэсэн гурван том хэсэгт хуваагдан Төвийн түмэн гурван гол (Хэрлэн, Онон, Туул)-ын саваар Монгол орны үндсэн хэсгийг хамаарч Баруун түмэн Алтайн уулсын сав газар, Зүүн түмэн



Хянганы нуруунаас нааш нутгийг эзэмших болжээ. Ийнхүү монголчууд өнө эртнээс эхлэн үеийн үед суурьшин амьдрахдаа хангай, говь, хээр тал хосолсон нутгаа ихэвчлэн уртрагийн дагуу эзэмшин ашиглаж, мал сүргийнхээ бэлчээрийн тэнцвэрийг ханган, нүүдэллэн нутаглаж ирсэн бөгөөд энэ уламжлал эдүгээ ч хадгалагдсаар байна.


1921 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалаас хойш нийгэм, эдийн засгийн орон зайн зохион байгуулалтын хүрээнд үйлдвэр, үйлчилгээний газрууд, төвлөрсөн хот суурингууд үүсэж, хотжих хандлага эхэлсэн ч нүүдлийн аж ахуй, соёлын уламжлалт сэтгэлгээ өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн билээ.

Эдийн засгийн бүсчлэлтэй холбоотой асуудлыг 1920-оод оны сүүлчээс Монгол Улсын шинжлэх ухааны анхны байгууллага болох Судар бичгийн хүрээлэнгийн Газарзүйн тасаг судалж эхэлсэн.

1931 онд Засгийн газраас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг судлан тогтоох үүрэг бүхий тусгай комисс байгуулав. Тэрхүү комиссын саналаар аж ахуйн хөгжилд нөлөөлөх байгаль, газарзүйн шинжүүд, зам харилцааны нөхцөл, шинэ аймаг, бүсийн төв болохуйц суурин газруудын байршил, газар нутгийн асуудал хийгээд үндэсний цөөнхийн байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж, таван аймаг, худалдааны зургаан бүс, МАА-н найман бүсийн оронд засаг захиргаа-эдийн засгийн 13 аймаг байгуулах шийдвэр гаргажээ.


1940 онд шинээр батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулиар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг 18 аймгаар тогтоосон нь 1992 он хүртэл өөрчлөгдөөгүй.

Зураг 1. Засаг захиргаа-эдийн засгийн 13 муж (1934)



Эх сурвалж: Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр, 2019

Зураг 2. Эдийн засгийн бүсчлэлийн схем (1961)



Эх сурвалж: Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр, 2019

Үйлдвэрлэх хүчний нутаг дэвсгэрийн байршил, харилцаа хамаарлыг судлах ажилд 1950-аад оны сүүлчээр нэлээд ахиц гарч “Умард Монголын төв хэсгийн эдийн засгийн газарзүйн тодорхойлолт” (1957), “Монголын Дорнод хэсгийн эдийн засгийн газарзүйн тодорхойлолт” (1958), “БНМАУ-ын Хангайн мужийн эдийн засгийн газарзүйн тодорхойлолт” (1960) зэрэг бүтээлүүд хэвлэгджээ.

Монгол, Зөвлөлтийн эрдэмтэд 1961 оноос судалгаа явуулсны дүнд Төв, Дорнод, Өрнөд гурван бүс тогтоох үндэслэл боловсруулсан схемийг 1990-ээд он хүртэл бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөнд хэрэглэж байв.

Академич Б.Гунгаадаш “БНМАУ-ын эдийн засгийн Төв муж” (1967) бүтээлдээ Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран боловсруулсан бүсчлэлийн схемийг нарийвчлан Төв бүсийг дотор нь Ерөө-Туулын (Улаанбаатарын аж үйлдвэрийн зангилаа, Дарханы аж үйлдвэрийн зангилаа, Төв, Сэлэнгэ аймаг), Хангай-Хөвсгөлийн (Эрдэнэтийн аж үйлдвэрийн зангилаа, Булган, Хөвсгөл, Архангай), Онги-Байдрагийн (Өвөрхангай, Баянхонгор), Говийн (Дорноговь, Дундговь, Өмнөговь) гэсэн дөрвөн дэд муж, Өрнөд бүсийг дотор нь Завхан-Бигэрийн (Завхан, Говь-Алтай), Увс-Ховдын (Увс, Ховд, Баян-Өлгий) гэсэн хоёр дэд муж болгох санал дэвшүүлж, бүс нутаг, дэд мужийн тодорхойлолт өгсөн байдаг.

Ижил төрлийн амьтан ургамалтай, газарзүй, байгаль, цаг уурын нөхцөлөөр ойролцоо том хэмжээний газар нутгийг эко бүс гэдэг.



Монгол Улсын Үндсэн хуульд “...бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх...” гэж заасан нь нийгэм-эдийн засгийн шинэ харилцааны нөхцөлд төрөөс баримтлах бодлогын эрх зүйн үндэс болсон юм.

2001 онд УИХ-аас 9 дүгээр тогтоолоор Улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг буюу Мянганы зам, босоо тэнхлэгийн Боршоо-Ярант, Ханх-Бургастай, Бага Илэнх-Шивээ хүрэн, Алтанбулаг-Замын Үүд, Эрээнцав-Бичигт гэсэн таван чиглэлийг батлан хэрэгжүүлж эхэлсэн нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хүч нөөцийг татан, төвлөрүүлэх бодлогын суурь болсон төдийгүй Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын суурь болсон юм.

Монгол орны 1980-1990 оны их бүтээн байгуулалтын үед боловсруулсан “Монгол Улсын нутагшил хөгжлийн ерөнхий төсөл”-ийн баримт бичгийг 1996 онд УИХ-д өргөн барьсан нь үндсэндээ дөрвөн парламентын нүүр үзэж, улмаар 2001 онд “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-аас батлагджээ.

Энэхүү үзэл баримтлалд Монгол Улсын төрөөс бүсчилсэн хөгжлийн талаар хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тогтворжуулах, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах зорилготой байсан билээ. Ийнхүү улс, орны эдийн засгийн хөгжлийг Баруун (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд), Хангайн (Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл), Төвийн (Говьсүмбэр, Дархан-Уул,


Эдийн засгийн бүс гэдэг нь үйлдвэрлэлийн ямар нэгэн чиглэлээр төрөлжиж, улмаар нийгмийн хөдөлмөрийн хуваарийн дагуу бусад хэсэгтэйгээ нягт холбогдсон нутаг дэвсгэрийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм.

Зураг 3. Бүсүүдийг дэд мужуудад хуваах хувилбар (1967)



Эх сурвалж: Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр, 2019

Зураг 4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тодорхойлсон бүс (2001)



Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал, 2001

Эдийн засгийн зохистой бүсчлэлийн ерөнхий шалгуур бол байгаль орчны аль болох тохиромжтой нөхцөл, хангалуун нөөцөд түшиглэн бүтээгдэхүүнийг хамгийн бага хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, тээвэрлэлт, логикийн борлуулалтын нийлмэл зардлын түвшнийг хангах явдал юм.

Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв), Зүүн (Дорнод, Сүхбаатар, Хэнтий), Улаанбаатарын бүс (нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд) гэсэн таван бүсээр төлөвлөж, зохицуулахаар тусгасан юм.

"Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д төрийн байгуулалтын, эдийн засгийн, нийгэм, соёлын, байгаль орчны, хүн ам, хот байгуулалтын, гадаад хамтын ажиллагааны гэсэн үйл ажиллагааны зургаан хүрээг тодорхойлж, таван бүсийг тогтоосон. Эдгээр бүсүүдэд хөгжлийн тэнцвэрийг хангах, бие даасан байдлыг дээшлүүлэх, суурин болон нүүдлийн амьдралын хэв маягийг оновчтой хослуулах зарчмаар хүн ам, үйлдвэрлэлийн бөөгнөрлийг задалж, бүс хоорондын хөгжлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг халах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх гол зорилгыг хэрэгжүүлэхээр тусгасан. Эдийн засгийн голлох салбарууд болох мал аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувилал, нийгмийн үйлчилгээ зэргийг бүс нутгуудад нийтлэг байдлаар, харин тус тусын онцлогт тулгуурласан усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй зэрэг салбарыг ялгаатайгаар хөгжүүлэхээр төлөвлөсөн.



Мөн Монгол Улс урьд өмнө боловсруулан баталж, мөрдөн хэрэгжүүлж байсан бүхий л хөгжлийн бодлогодоо бүсчлэл, тэдгээрийнхээ нөөц боломжид тулгуурласан хөгжлийн концепцыг агуулж ирсэн. УИХ-аас 2001 онд баталсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” болон эрх зүйн бусад зохицуулалт, бодлого, төлөвлөлтийн хүрээнд “Чөлөөт бүсийн тухай хууль” (2002), “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль” (2003), “Бүсийн тулгуур төв хот тогтоох тухай” УИХ-ын тогтоол (2003), “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги” (2003), “Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр” (2005) зэрэг баримт бичгийг баталж, хэрэгжүүлсэн билээ.

Хэдийгээр сүүлийн 20 жилд “Бүсчлэн хөгжих нь зүйтэй” гэдэг үзэл хандлагыг бодлогын түвшинд тодорхойлсон боловч УИХ-ын сонгуулийн мөчлөгтэй холбоотой төсөв санхүүжилтийн дутагдал, өөрчлөлт, төсвийн төсөөлөлтэй холбоотой хэрэгжилтийн тогтворгүй байдал нь бүсчилсэн хөгжлийн бодлого алдагдахад хүчтэй нөлөөлсөн гэж үзэж болно.

Үүний тод жишээ нь тодорхой хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар төсөвлөн зарцуулсан ч өнөөгийн байдлаар **баруун бүсэд** эрчим хүчний тогтвортой эх үүсвэр бүрэлдээгүй, замын сүлжээ дутагдалтай хэвээр, хувийн хэвшлийн тэргүүлэх аж ахуйн нэгж төдийлөн хөгжөөгүй байна. **Хангайн бүс** нь аялал жуулчлал, байгалийн баялгийн арвин нөөцтэй ч эдийн засгийн хувьд гадаад, дотоод зах зээлтэй холбох дэд бүтцийн сүлжээ, хойд урд хөрштэй тогтмол харьцах хилийн боомт, экспортын гарц багатай хэвээр байна. **Төвийн бүс** нь газар тариалангийн бүс нутагт тооцогддог, Ази, Европыг холбосон олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаа, тээвэр логистикийн боломжтой ч ахиц дэвшил бага байна. **Зүүн бүсийн** хувьд Монгол Улсыг Зүүн Азийн орнуудтай холбох газарзүйн ойр дөт байрлалд тулгуурлан хөгжих боломж дүүрэн.

Ийнхүү Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал үр дүнтэй хэрэгжиж чадаагүй голлох шалтгааныг тодорхойлсноор урт хугацааны хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтэд анхаарах сургамж болох билээ. Тухайлбал, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, бүс нутгийн хөгжлийн асуудлыг зохицуулах чиг үүргийг Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн яам хариуцахаар заасан нь чиг үүргийн хувьд оновчтой шийдэл болж чадаагүй бөгөөд бүс нутгийн хөгжлийн үйл явцад оролцогч талуудын үйл ажиллагааг оновчтой зохицуулж, уялдааг хангаж чадаагүй байна.

Мөн бүсийн төлөвлөлт нь салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх асуудалтай нягт уялдаатай боловч энэ уялдааг

Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр УИХ-аас дараах тогтоолыг хэлэлцэн баталжээ.

- “Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай” УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоол;
- “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол;
- “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2002 оны 23 дугаар тогтоол;
- “Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” УИХ-ын 2003 оны 01 дүгээр тогтоол.

Эдийн засгийн хувьд уул уурхай, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал болон боловсруулах үйлдвэрийн чиглэлээр бүсчлэл тогтоохдоо хилийн бүс нутаг, байгаль орчны онцлог, тээвэр логистикийн боломжийг харгалзан хөгжүүлэх шаардлагатай.

хангаж, оролцогч талууд зөвшилцөж, нэгдсэн ойлголт, шийдэлд хүрч ажиллаагүй төдийгүй улс орнуудын туршлага, сургамж, бүс нутгийн шинжлэх ухааны онол, арга зүйг ашиглах нь хангалтгүй хэвээр байсан. Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегид тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх тууштай бодлогогүй явж ирсэн. Бодлогын хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлт, үйл явцын өрнөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлсон хөтөлбөрийн дагуу ажиглах, хянах, үр дүнг үнэлэх, тэдгээрийг задлан шинжлэх, мэдээлэх тогтолцоо буюу нутаг дэвсгэрийн мониторингийн тогтолцоо бүрдээгүй.

Бүсийн дэд бүтцийн тэнхлэгүүдийн замыг барих ажлыг орхигдуулж оронд нь аймгуудыг найман цацраг замаар Улаанбаатар хоттой холбосон нь Улаанбаатар хотын хэт төвлөрлийг нэмэгдүүлж, орон нутгийн хүн амын амьжиргааны өртгийг давхар тээврийн зардлаар нэмэгдүүлсэн хэвээр үлдсэн юм.

Аливаа томоохон агломерац хөгжлийн импульс дамжуулах орон зай, өөрийн нөлөөний хүрээ гэж бий. Бусад оронд нийтлэг хэрэглэгдэж ирсэн хот, суурин газруудын харилцан үйлчлэл, тэдгээрийн энгийн болон хэв шинжийн ангилал, зэрэглэлийг тогтоох, эдийн засгийн газарзүйн байрлал, үүргийг судлах, хот суурин газарт үйлдвэрлэлийг байршуулах талаарх онол, арга зүйг ашиглах явдал хангалтгүй байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд амьдралын харьцангуй ойролцоо нөхцөлийг бүрдүүлэхийн тулд амьжиргааны өртөгт нөлөөлж байгаа зам, тээврийн зардал өртгийг бууруулах арга зам бол дэд бүтцийг шийдвэрлэх явдал юм. Босоо тэнхлэгээр хөрш орнуудыг холбосон дэд бүтцийн транзит сүлжээг бүс бүрд бий болгож худалдааны болон түүхий эд бэлтгэлийн тогтолцоог өргөтгөх, хүн амын өргөн хэрэглээний бараа татах, худалдааны эргэлтийг сайжруулах шаардлагатайг судлаачид онцолдог.

Бэлчээрийн мал аж ахуйн ашиг шимийг дээшлүүлж, үр өгөөжийг нэмэгдүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад хангай, говь дамнасан уламжлалт бүсчлэл ихээхэн чухал юм. Орон нутагт ажилгүйдлийг бууруулж, нийгмийн үйлчилгээний тэгш бус байдлыг багасгаж, орлогын түвшний зөрүүг бууруулах бодлого баримтална. Эдгээр нь макро эдийн засгийн хөгжлийн бодлогоор хангагдсанаар бүс нутаг бүрд дэд бүтэц болон хөгжлийн тэнцвэртэй оролцоог дэмжих юм.



БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИН, БОЛОМЖ

Бүс нутгийн хөгжлийг дэмжих бодлогын тэгш хүртээмжтэй хэрэгжилтийг тухайн цаг үед нь хэмжин алдаа оноо, асуудлын шийдлээ тодорхойлох нь нэн чухал юм. Орон нутгийн хөгжлийг өрсөлдөх чадвараар нь хэмжихдээ эдийн засгийн чадавх, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн дөрвөн үндсэн бүлгийн хүрээнд 181 шалгуур үзүүлэлтээр үнэлж тооцож байна.

Манай улсад орон нутгийн хөгжил, тэр дундаа сумдын хөгжлийн үзүүлэлтүүд тааруу байгаа нь иргэдийн хот, сууринг чиглэсэн шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгаан болж байна. Малчид, тариаланчдын амьжиргааны гол эх үүсвэр болох хөдөө аж ахуй нь байгаль, цаг уурын нөхцөл, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, хэт хамааралтайн дээр өрсөлдөх чадвар, эдийн засгийн багтаамж нь улам бүр багассаар ирсэн нь тэдний хот, суурин газарт шилжин амьдрах хандлагад хүчтэй нөлөө үзүүлсэн. 1998-2002, 2010 онд улсын хэмжээнд олон жил дараалан ган, зуд нүүрлэж, орон нутгийн иргэдийн амьжиргаа муудсан нь шилжих хөдөлгөөнийг улам нэмэгдүүлснийг “Шилжих хөдөлгөөн, суурьшлын сэдэвчилсэн судалгаа”-аас харж болно.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах нь орон нутагт аж төрөх боломж бололцоог нэмэгдүүлэн, алслагдсан, зах хязгаар нутаг эзэнгүйдэж хаягдах, цаашилбал, үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

Хүснэгт 1. Орон нутгийн хөгжлийн үзүүлэлт 21 аймгаар (2020)

#	Аймаг	Ерөнхий үзүүлэлт	Боловсрол	Эрүүл мэнд	Ядуурал	Эдийн засаг	ДНБ	Дэд бүтэц	Байгаль орчин	Бусад
1	Өмнөговь	0.67	0.73	0.83	1.00	0.28	0.07	0.57	0.86	0.92
2	Дархан Уул	0.58	0.57	0.80	0.48	0.23	0.16	0.61	0.78	0.66
3	Орхон	0.57	0.55	0.78	0.67	0.27	0.06	0.56	0.58	0.79
4	Дорноговь	0.55	0.59	0.82	0.71	0.28	0.14	0.26	0.79	0.67
5	Сэлэнгэ	0.54	0.51	0.79	0.45	0.24	0.13	0.48	0.81	0.63
6	Увс	0.54	0.53	0.76	0.56	0.27	0.18	0.38	0.82	0.67
7	Архангай	0.53	0.56	0.77	0.35	0.22	0.15	0.38	0.84	0.69
8	Сүхбаатар	0.53	0.56	0.77	0.55	0.22	0.15	0.40	0.72	0.60
9	Булган	0.53	0.53	0.79	0.38	0.21	0.15	0.42	0.78	0.65
10	Төв	0.53	0.52	0.79	0.79	0.23	0.13	0.35	0.84	0.61
11	Дундговь	0.52	0.55	0.82	0.76	0.23	0.14	0.24	0.86	0.62
12	Баянхонгор	0.52	0.53	0.81	0.56	0.22	0.16	0.27	0.83	0.70
13	Завхан	0.51	0.54	0.79	0.66	0.24	0.15	0.23	0.89	0.61
14	Говьсүмбэр	0.51	0.43	0.79	0.01	0.25	0.14	0.48	0.94	0.53
15	Баян-Өлгий	0.51	0.54	0.80	0.69	0.21	0.23	0.23	0.77	0.66
16	Говь-Алтай	0.51	0.55	0.80	0.18	0.26	0.14	0.20	0.82	0.70
17	Өвөрхангай	0.50	0.53	0.79	0.45	0.21	0.18	0.23	0.87	0.63
18	Хэнтий	0.50	0.53	0.79	0.36	0.26	0.17	0.21	0.90	0.55
19	Хөвсгөл	0.50	0.51	0.76	0.67	0.23	0.20	0.19	0.89	0.64
20	Дорнод	0.49	0.52	0.78	0.24	0.29	0.11	0.17	0.85	0.56
21	Ховд	0.49	0.51	0.77	0.28	0.25	0.16	0.18	0.87	0.67

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар, 2021


Монгол Улсад 1990-ээд он хүртэл иргэдийн дураараа шилжин суурьшихыг хязгаарладаг, зайлшгүй тохиолдолд хороо захиргаанаас зөвшөөрөл, тодорхойлолт авдаг байв. Мөн хот, хөдөөд нийгмийн үйлчилгээг адил тэгш байлгах, сайжруулах болон хүн бүрийг ажлын байраар хангахад анхаардаг байсан.

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд аймгуудаас шилжин явагсдын тоо нэг сая шахаад байна. Ялангуяа Говь-Алтай, Завхан, Увс, Булган, Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Дундговь, Сэлэнгэ, Төв аймгийн хүн амын талаас илүү хувь нь шилжин явжээ. Хүн амын ердийн цэвэр өсөлтөөс давсан шилжих хөдөлгөөний үр дагавраар энэ хугацаанд ихэнх аймгийн хүн ам өсөөгүй үзүүлэлттэй харагдаж байна. Шилжин суурьшигчдыг хот, суурин газарт хэт төвлөрлөөс үүсэх хүндрэлүүд нь нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүртгээмжтэй авах, шилжин суурьшсан зорилгоо хангахад хүндрэл учруулж байна.

Ямар ч зохицуулалтгүй олон жил үргэлжилсэн шилжилт хөдөлгөөний улмаас хөдөө нутаг, ялангуяа хязгаар нутгууд эзгүйрч, сумдын хөгжил цаг үеэсээ эрс хоцрогдсон. Иймд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бүс, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг хийхдээ бүсийн дэд бүтцийг дагуулан сумдыг хөгжүүлэх боломж, нөөц, хөрөнгө зардал, эдийн засгийн болон бусад чадавх, олон талын хүчин зүйлийг бүсийн баримжаатайгаар тооцож тусгасан юм.

Бүс нутгийн хөгжлийг дэмжих, тус тусын онцлогтой, харилцан уялдсан байдлаар хөгжүүлэх бодлогыг тодорхойлохдоо аймаг, сум тус бүрийн өнөөгийн төлөв байдал, нөөц боломж, байгалийн болон эдийн засгийн нөхцөл, хүрсэн түвшин, суурилагдсан хүчин чадал зэрэг бүхий л үзүүлэлтийг тооцож үздэг.

Зураг 5. Аймгуудаас нийт шилжин явагчдын тоо (2000-2020 он)



Эх сурвалж: Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, 2022



АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ, НӨӨЦ БОЛОМЖ

Аймаг тус бүрээр газарзүйн нөхцөл байдал, хөгжлийг хязгаарлаж буй асуудал болон цаашдын хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломжийг тодорхойлж, аймгийн хөгжлийн дүн шинжилгээ хийх нь бүс, орон нутгийн хөгжлийн бодлогод чухал ач холбогдолтой. ВХБЯ, ҮХГ, ЖАЙКА-ийн “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн баг аймгуудын хөгжлийн хэтийн төлөв, нөөц боломжийг тодорхойлсныг өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй эдийн засгийн таван бүсээр ангилж харуулав.

БАРУУН БҮС: БАЯН-ӨЛГИЙ, ГОВЬ-АЛТАЙ, ЗАВХАН, УВС, ХОВД



БАЯН-ӨЛГИЙ

ДНБ: 550,814,000₮

ХҮН АМ: 108,376

МАЛЫН ТОО: 2,379,010


- Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр баригдаж буй АН-4 олон улсын авто замыг түшиглэж, Өлгий хотод боловсруулах үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалын салбаруудыг уялдуулж хөгжүүлэх;
- Цагааннуурын чөлөөт бүсэд түшиглэж, ОХУ-тай холбогдсон эдийн засгийн коридорыг хөгжүүлэх;
- Хагас эрчимжсэн МАА-г хөгжүүлж, бүтээгдэхүүнийг үе шаттайгаар төрөлжүүлэх;
- Механикжуулалт, усжуулалтын системийг ашиглаж, эрчимжүүлсэн фермерийн аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх;
- Жимс жимсгэнэ, самрын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Олон ястны соёл, зан заншилд түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Усан цэнэгт цахилгаан станцыг барьж байгуулах.

УВС

ДНБ: 577,844,500₮

ХҮН АМ: 85,314

МАЛЫН ТОО: 3,726,400




- ОХУ-тай холбогдсон Баруун бүсийн барилгын материалын худалдаа, логистикийн төв болох;
- Боршоо хилийн боомтын үйл ажиллагааг өргөжүүлэх;
- Байгальд түшиглэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Малын тэжээл зэрэг үр тариа тарих газрыг нэмэгдүүлэх;
- Газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах, ялангуяа чацарганын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх;
- Зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- МАА эрхлэлт, бэлчээрийн менежментэд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах.

ХОВД


ДНБ: 699,585,300₮

ХҮН АМ: 90,333

МАЛЫН ТОО: 3,596,970



- Ховд голын усан цахилгаан станцыг ойрын ирээдүйд ашиглалтад оруулах;
- Хагас эрчимжсэн МАА, малын тэжээлийн үйлдвэр, экспортын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх;
- Малын тэжээл болон бусад төрлийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор усжуулалтын системийг сайжруулах;
- “Ногоон хөгжлийн загвар аймаг” болгож хөгжүүлэх;
- Байгаль орчин, цэнгэг болон давст нуур, уул нурууд, цэлгэр хөндий, агуй, хадны сүг зураг, хэрэм зэрэг дурсгалт газруудад түшиглэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх;
- Ховд хотын нисэх буудлыг олон улсын нисэх буудал болгож өргөжүүлэх;
- Ховд хотыг ОХУ-тай арилжаа худалдаа хийх, Баруун бүсийн аж үйлдвэрийн төв болгож хөгжүүлэх.




ЗАВХАН

ДНБ: **553,324,000₮**

ХҮН АМ: **73,802**

МАЛЫН ТОО: **3,755,160**

- Нийгмийн үйлчилгээ, засаг захиргааны үйл ажиллагааг сайжруулах;
- Экспортод чиглэсэн ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;
- БНХАУ болон ОХУ-ын зах зээлд сайн чанарын мах, сүү сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх, МАА-н салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээг нэвтрүүлэх;
- Хархорин, Цэцэрлэг, Баянхонгор зэрэг Хангайн бүсийн аялал жуулчлалын кластерт холбогдож, дотоодын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх;
- Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх.



ГОВЬ-АЛТАЙ


ДНБ: **370,765,900₮**

ХҮН АМ: **58,735**

МАЛЫН ТОО: **2,990,510**

- Тусгай хамгаалалттай өргөн уудам газар нутагт тулгуурлан зэрлэг онгон байгаль, өв соёлын урт хугацааны аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг бэлтгэх сургалтын төв, эрүүл мэнд болон боловсролын үйл ажиллагаа, материаллаг баазыг бэхжүүлж, Алтай хотыг аялал жуулчлалын суурь болгон хөгжүүлэх;
- Аймгийн өмнөд хэсэгт нарны цахилгаан станцыг барьж байгуулан, газрын гүний дулааныг хуримтлуулж, эрчим хүч үйлдвэрлэх боломжийг судлан сэргээгдэх эрчим хүчний төвүүдийг байгуулах;
- Улирлаар бэлчээр сэлгэн, хагас эрчимжсэн МАА-г дэмжих;
- Зах зээлд нийлүүлэх сайн чанарын ургац хураахын тулд хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх;
- Газрын гүний дулааны энергийн нөөцийг ашиглан бүс нутгийн хэмжээний эрчим хүчний үйлдвэрлэл хөгжүүлэх;
- Завхан голын усан цахилгаан станцын даланг цахилгаан үйлдвэрлэл, усжуулалт, ус хангамж зэрэг олон зориулалтаар ашиглах.

ХАНГАЙН БҮС: АРХАНГАЙ, БАЯНХОНГОР, БУЛГАН, ОРХОН, ӨВӨРХАНГАЙ, ХӨВСГӨЛ




ХӨВСГӨЛ

ДНБ: **826,586,000₮**

ХҮН АМ: **137,628**

МАЛЫН ТОО: **5,943,210**

- Байгалийн, эрүүл мэндийн, соёлын болон бусад төрлийн аялал жуулчлалыг төрөлжүүлэн, нэгдсэн байдлаар хөгжүүлэх;
- Жуулчдыг шинэ жимс, ногоо, махан бүтээгдэхүүн, боловсруулсан бяслаг, нутгийн шар айраг болон зөгийн балаар хангах, энэ чиглэлээр газар тариаланг дэмжих;
- Эрдэнэт, Дархан хотуудад шинэ мах, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Ойг үнэлэх, ойн дагавар нөөцийг тодорхойлох нөөцийн цогц бүртгэл хөтлөх;
- Аялал жуулчлалын салбарыг өргөн цар хүрээнд хөгжүүлэн, олсон орлогоор дэд бүтэц барьж байгуулах, ойн санг хамгаалах.



БУЛГАН

ДНБ: 485,204,800₮

ХҮН АМ: 61,938

МАЛЫН ТОО: 3,622,250


- Байгалийн нөөцөөс хамааралтай бус, байгаль орчинд ээлтэй эдийн засаг бүхий загвар аймаг болохын төлөө тэмүүлэх;
- Дунд оврын техник, тоног төхөөрөмж бүхий анхан шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ажиллах хүчний оролцоог дэмжсэн үйлдвэрийг нэмэгдүүлэх;
- Газар тариаланг механикжуулж, усалгааны байгууламжуудыг сайжруулж, шинэчлэн засварлах замаар ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтээмжийг дэмжих;
- Эрчимжсэн МАА болон өндөр ургацтай газар тариаланг хослуулж, аймгийн төвийн боловсруулах үйлдвэрүүд, гол зам дагуух газруудтай холбож хөгжүүлэх;
- Улаанбаатар хотыг Эрдэнэт болон Мөрөн хоттой холбосон аялал жуулчлал, арилжаа худалдааны коридорыг хөгжүүлэх.

АРХАНГАЙ


ДНБ: 733,913,000₮

ХҮН АМ: 95,867

МАЛЫН ТОО: 5,562,170



- Боловсруулах үйлдвэр бүхий МАА-н үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх;
- Боловсруулах үйлдвэр хөгжүүлэх зорилгоор сонгогдсон хотуудын дэд бүтцийг сайжруулах;
- МАА-н үйлдвэрлэлийн кластерыг дэмжих зорилгоор малын тэжээл үйлдвэрлэлийг дэмжих;
- Цэцэрлэг хотыг түшиглэсэн байгалийн аялал жуулчлал, өвлийн амралт зугаалгын газрыг хөгжүүлэх;
- Малчдад зориулсан зайнаас эмнэл зүйн зөвлөгөө өгөх (телемедицин), алсын зайны сургалт зохион байгуулах, цаг уурын урьдчилсан мэдээлэл өгөх, МАА-н кластерыг дэмжих, аялал жуулчлалын мэдээлээр хангах мэдээлэл, харилцаа холбооны технологийг өргөн нэвтрүүлэх.




БАЯНХОНГОР

ДНБ: 347,591,500₮

ХҮН АМ: 89,975

МАЛЫН ТОО: 3,127,120

- Баянхонгор, Арвайхээр, Цэцэрлэг хотуудын чиг үүргийг зааглан хуваарилж, хотын хөгжлийг хамтран дэмжих;
- Эрчимжсэн МАА-г аймгийн төвийн ойролцоо болон Алтай, Арвайхээр хот орох зам дагуу байршуулах;
- Халуун рашаан, арвин их эмийн ургамал дээр түшиглэн эрүүл мэндийн аялал жуулчлалыг дэмжих;
- Эмийн ургамлын иж бүрэн судалгаа хийх, ирээдүйтэй төрөл, зүйлүүдийг сонгох, брэнд хөгжүүлэлт хийх, сурталчлах зорилгоор судалгааны төв байгуулах;
- МАА-н бүтээгдэхүүн, жимс, жимсгэнэ, эмийн ургамлыг боловсруулах орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах;
- Говийн бүсэд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх ажлын хүрээнд орон нутгийн сэргээгдэх эрчим хүчний боломжуудыг ашиглах.



ӨВӨРХАНГАЙ

ДНБ: **583,417,100₮**

ХҮН АМ: **117,261**

МАЛЫН ТОО: **4,022,690**

- Шивээхүрэн-Сэхээгийн хилийн боомтоор БНХАУ руу ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход хойд болон баруун аймгуудын гарц болох;
- ОХУ руу экспортлох бүтээгдэхүүнүүдийг хөдөө орон нутгаас төвлөрүүлэх төв болох;
- Улсын төв хэсэгт байрлаж буй газарзүйн давуу талаа ашиглан логиستيкийн салбарыг хөгжүүлэх;
- Боловсруулах үйлдвэр бүхий МАА-н үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх;
- Хархорин болон Орхоны хөндий орчимд байгалийн болон өв соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх.

ОРХОН

ДНБ: **2,871,500₮**


ХҮН АМ: **106,145**

МАЛЫН ТОО: **154,580**



- Эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэл хосолсон нэгдсэн аж ахуйг хөгжүүлэх;
- Зах зээлд өндөр үнэ цэн бүхий бүтээгдэхүүнийг нийлүүлэх хүлэмжийн аж ахуй болон бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Арьс шир, хvнс болон бусад хөнгөн үйлдвэрийг төрөлжүүлэн, хөгжүүлэх;
- Эрдэнэт хотыг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх болон Улаанбаатар, Хөвсгөл, ОХУ чиглэлийн аялал жуулчлалын түшиц газар болгон хөгжүүлэх;
- Соёлын болон эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Ногоон байгууламжтай, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, уурхайн нөхөн сэргээлт, арчилгаа тордолт бүхий хариуцлагатай загвар уурхай болгон хөгжүүлэх.

ТӨВИЙН БҮС: ГОВЬСҮМБЭР, ДАРХАН-УУЛ, ДОРНОГОВЬ, ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ, СЭЛЭНГЭ, ТӨВ



ДАРХАН-УУЛ

ДНБ: **734,811,900₮**

ХҮН АМ: **104,737**

МАЛЫН ТОО: **355,330**

- Ногоо, жимс зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүднээс Хараа голын усыг ашиглан усны хэмнэлттэй усалгааны систем байгуулах;
- Хүлэмжийн болон гидропоник технологийн тусламжтайгаар газар тариалангийн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Дархан хотыг Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан дэвшилтэт мал аж ахуйн туршилтын бааз суурь болгон хөгжүүлэх;
- Одоо байгаа цемент, ган, арьс шир, хоол хүнсний үйлдвэрлэлийг мэдээлэл, харилцаа холбооны технологийн тусламжтайгаар өргөжүүлэх;
- Төвлөрлийг сааруулах үүднээс орон нутгийн бие даасан байдлыг дэмжих.




СЭЛЭНГЭ

ДНБ: 1,021,542,400₮

ХҮН АМ: 168,887

МАЛЫН ТОО: 1,886,740




- Усны хэмнэлттэй усалгаа, хүлэмж болон гидропоник технологи зэрэг газар тариалангийн шинэ технологиудыг нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх;
- Бага оврын усан цахилгаан станц барих;
- Шувуу болон гахайн аж ахуй бүхий эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;
- Газар тариалангийн үйлдвэрлэл, хадгалалт, боловсруулалтын иж бүрэн систем бий болгох;
- Сэлэнгэ аймгийн үзэсгэлэнт байгаль, Азийн өвөрмөц соёл болон Буриадын түүх, Байгаль нуурын гоо үзэмжийг хамтатган олон нийтэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Худалдаа арилжаа, шинэ технологи болон мэдээллийн суурь болгон Чөлөөт худалдааны Алтанбулаг бүсийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих.

ТӨВ

ДНБ: 821,412,600₮

ХҮН АМ: 94,042

МАЛЫН ТОО: 4,746,040




- Улаанбаатар хотын зарим чиг үүргийг хэрэгжүүлэх хот болон хөгжих;
- Орчин үеийн дэвшилтэт технологи болон гадаадын шинэлэг дизайны санааг нэвтрүүлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц бараа бүтээгдэхүүн экспортлох зорилгоор хотын хөгжлийн шинэ төвийг бий болгон "Шинэ Зуунмод" хотыг хөгжүүлэх;
- Улаанбаатар хотын гадна тойрог маягаар үйлдвэрлэл, логистикийн таван бааз суурийг шинээр байгуулах;
- Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг эко аялал жуулчлал чиглэлээр хөгжүүлэх;
- Сэлэнгэ аймагт ойрхон, Туул голын сав газар дагуу хүлэмжийн аж ахуй, усжуулалтын систем, бусад дэвшилтэт аргуудыг нэвтрүүлснээр газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Улаанбаатар хотын иргэдэд зориулан амралт, аялал зугаалгын бүсийг хөгжүүлэх, дотоодын аялал жуулчлалыг дэмжих.

ДУНДГОВЬ


ДНБ: 332,545,800₮

ХҮН АМ: 47,542

МАЛЫН ТОО: 3,170,480



- Дөрвөн чиглэлд дамжин өнгөрөх цэгийн хувьд Мандалговь хотыг логистик, түгээлтийн төв болгон хөгжүүлэх;
- МАА болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, БНХАУ руу боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох;
- Улаанбаатар хот болон БНХАУ-ын эрэлт ихтэй зах зээлд нийлүүлэх зорилгоор сайн чанарын мах, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Хязгаарлагдмал ашигт малтмалын нөөц, түүний боловсруулалтад суурилан хариуцлагатай уул уурхайг дэмжих;
- Соёлын болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- МАА, уул уурхай, аялал жуулчлалд тулгуурлан Говийн брэндийг бий болгох.




ДОРНОГОВЬ

ДНБ: **2,706,800₮**

ХҮН АМ: **72,113**

МАЛЫН ТОО: **595,689,500**

- Сайншанд хотыг логистик болон аялал жуулчлалын чиг үүрэгтэйгээр хөгжүүлэн, Сайншанд – Замын-Үүдийн эдийн засгийн коридорыг хөгжүүлэх;
- Сайншанд хотыг аялал жуулчлалын бааз суурь, аймгийн өмнөд хэсгийн говьд өв уламжлал болон онгон байгалийн аялал жуулчлалыг, Замын-Үүдэд хилийн бүс орчмын аялал жуулчлалыг тус тус хөгжүүлэн, тэдгээрийг холбох;
- Орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах үүднээс эмийн ургамал түүх, ашиглах, тарималжуулах;
- Байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах үүднээс хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх;
- Уул уурхайн ашгаас нийгмийн хөгжлийн сан байгуулах;
- Бохир усыг дахин боловсруулах, ашиглах байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- Хээрийн болон цөлөрхөг нутгийг хээрийн судалгааны газар болгон ашиглах.




ГОВЬСҮМБЭР

ДНБ: **114,116,400₮**

ХҮН АМ: **18,153**

МАЛЫН ТОО: **432,200**

- Чойр логистикийн төв болон автомашины засвар үйлчилгээний төв байгуулах;
- Хөрш зэргэлдээ газар нутгийн ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах;
- Хүрэн нүүрсний их хэмжээний нөөцөд суурилсан цэвэр эрчим хүчний технологийн төв байгуулах;
- Мэдээлэл, харилцаа холбооны болон бусад үйлдвэрүүдэд зориулан хуучин цэргийн ангийн газарт худалдааны чөлөөт бүсийг дахин идэвхжүүлэх;
- Ус, тэжээлийн хангамжийг сайжруулах замаар эрчимжсэн мал аж ахуй эрхлэх;
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, иргэд амралтын өдрүүдээр очих, амралтын газар байгуулах.



ӨМНӨГОВЬ

ДНБ: **1,001,433,500₮**


ХҮН АМ: **72,943**

МАЛЫН ТОО: **2,513,810**

- БНХАУ-тай хилийн худалдаа хийх бааз болгон хөгжүүлэх;
- Өмнөговь аймгийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болох Таван толгойн нүүрсний уурхай, Оюутолгойн зэс, алтны уурхайн хөгжилд нөлөөлөх хилийн төмөр замын тээвэрлэлтийг сайжруулах;
- Ногоон хөгжлийн бодлогын нэгэн чухал хэсэг болох усны нөөцийн зохистой менежментийг бүрдүүлэх;
- Бусад аймгаас зорчин өнгөрч буй зорчигчид, ачаа барааг дамжин өнгөрүүлж, БНХАУ руу тээвэрлэх логистикийн төвийг хөгжүүлэх;
- Дрон ашигласан хяналт мониторингийн урьдчилан сэргийлэх систем, БНХАУ-тай интернэт худалдаа хийх, бүтээгдэхүүний байршлыг тогтоох, агро-технологийн парк зэргийг хөгжүүлэхэд мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглах;
- Байгалийн аялал жуулчлал болон зуны амралт, зугаалгын бүсийг хөгжүүлэх.



ЗҮҮН БҮС: ДОРНОД, СҮХБААТАР, ХЭНТИЙ



ХЭНТИЙ

ДНБ: 595,505,600₮

ХҮН АМ: 79,429

МАЛЫН ТОО: 4,954,960


- Эрчимжсэн МАА, малын тэжээлийн үйлдвэр хосолсон нэгдсэн аж ахуйг хөгжүүлэх;
- Ус хэмнэсэн, дэвшилтэт усалгааны технологийг нэвтрүүлж, газар тариалан, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх;
- Брэнд хөгжүүлж, соёлын болон орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, эмчилгээний эрдэст рашаан, эмийн ургамал агуулсан эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Аялал жуулчлалын түшиц, барилгын материалын нийлүүлэлт, хөдөө аж ахуйн нэгдсэн төв, ногоон хөгжлийн загвар бүхий Чингис хотыг хөгжүүлэх.

ДОРНОД

ДНБ: 921,860,300₮

ХҮН АМ: 84,575

МАЛЫН ТОО: 3,051,070




- ОХУ, БНХАУ-тай хийх худалдааг өргөжүүлэх, Монголын талаас логикийн дэд бүтцийг сайжруулах;
- Аймгийн брэнд бүтээгдэхүүнийг Эрэнцавын хилийн боомтоор Ази-Европ руу, Хавирга боомтоор Манжуур руу экспортлох;
- Чойбалсан хотыг олон улсын логистик, бизнесийн төв болгон хөгжүүлж, Зүүн бүсийн аймгуудын аялал жуулчлалын зангилаа хот болгох;
- Импортыг орлох, экспортлох ногоо, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх;
- Хагас эрчимжсэн МАА-г малын тэжээлийн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх;
- Дорнод аймгийн нисэх буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгон өргөжүүлэх.

СҮХБААТАР

ДНБ: 594,067,700₮

ХҮН АМ: 65,228

МАЛЫН ТОО: 4,202,940



- Эрчимжсэн мал аж ахуй, экспортын нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний боловсруулалт бүхий мал аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах;
- Бэлчээр, ус сайтай газар малаа оторлох;
- Малын өвчингүй бүс байгуулах, өндөр ашиг шимт малын удмын санг бий болгох;
- Байгаль орчинд ээлтэй технологи, уурхайн нөхөн сэргээлт хийдэг, хариуцлагатай, ухаалаг уул уурхайг хөгжүүлэх;
- Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хамруулан мал аж ахуйн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа, барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн, хөгжүүлэх;
- Авто замын сүлжээг сайжруулснаар байгаль, соёл, өв уламжлал, хилийн бүс орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Бичигт боомтын зам, барилга байгууламжуудыг өргөжүүлэх;
- Баруун-Урт хотын ус хангамжийг сайжруулах, усны шинэ эх үүсвэр барьж байгуулах.

ЗАРИМ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА


Дэлхий нийтийн эдийн засгийн либеральчлал, харилцан ашигтай хөгжих алс хэтийн хөгжлийн бодлогод улс орнуудын бүс нутгийн хэмжээнд баримталж буй бодлого чухал ач холбогдолтой. Хөгжлийн харилцан адилгүй түвшин бүхий улс орнууд өөр өөрийн онцлогт тохирсон бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг. Гэвч хөрш зэргэлдээ орнуудын худалдаа, эдийн засгийн харилцаа, зам тээвэр, дэд бүтцийн стратеги нягт уялдсан байх зүй ёсны шаардлага тавигдаж байна. Монгол Улсын стратегийн гол ордууд зөвхөн урд хөрштэй дэд бүтцээр холбогдсон байгааг анхаарч бүсийн дэд бүтцийн босоо таван тэнхлэгийн замуудыг байгуулж, олон улсад гарцтай болох нь Монгол Улсын хөгжилд чухал ач холбогдолтой. Монгол Улс хөгжлийнхөө хэтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлохдоо хоёр хөршийнхөө хэрэгцээ шаардлага, дэд бүтцийн стратеги төлөвлөгөөг баримжаалах шаардлагатай бөгөөд зах зээлийн шинэ эрэлтийг угтуулах зорилгын хүрээнд гуравдагч улсын хөгжлийн стратегийг ч давхар тооцож үзэх учиртай.

Япон улс

Япон улс засаг захиргааны хувьд нийслэл Токио хот (то), Хоккайдо хязгаар (до), мужийн статустай хоёр том хот Осака, Киото (фу), бусад 43 муж (кэн) гэсэн 47 нэгжид хуваагдах бөгөөд үүнийгээ тодофукэн гэнэ. Дараагийн түвшинд хот (ши), хошуу буюу уезд (гүн), тойрог (зөвхөн Хоккайдод байх ба ши-чо гэнэ) гэж дараалах ба ерөнхийдөө засаг захиргааны хуваарь нь таван шатлалт тогтолцоотой. 1990-ээд оны сүүлчээр газар нутгаа эдийн засгийн есөн бүсэд хуваасан тогтолцоо эдүгээ мөрдөгдөж байна.

Япон улс газар нутгаа 1990-ээд оны сүүлээр эдийн засгийн есөн бүсэд хуваасан тогтолцоогоо одоог хүртэл баримталж байна.

Зураг 6. Япон улсын муж ба эдийн засгийн бүсчлэл



Эх сурвалж: Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр, 2019




Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь дэлхийн хоёр дахь том эдийн засаг болж, нутаг дэвсгэрийн хэмжээгээр гуравт орж байгаа ч дотоодод нь муж, хязгаар, бүс нутгуудын түвшинд байгаль, түүх соёл, нийгэм-эдийн засаг, үндэстний асар их ялгаа өнө удаан жилээр хуримтлагдсан цөөн орны нэг юм.

1958 онд засаг захиргааны зургаан районыг өөрчлөн эдийн засгийн хамтын ажиллагааны долоон бүс нутгийг (Зүүн хойд, Умард, Баруун хойд, Зүүн, Төв, Өмнөд, Баруун өмнөд) тогтоож, байгалийн нөөцийг үр дүнтэй ашиглаж, бүс нутгуудын боломжийг дайчлан бүс бүрд бие даасан аж үйлдвэрийн цогцолбор байгуулах замаар үндэсний хэмжээнд тэнцвэртэй хөгжилд хүрэх зорилт дэвшүүлсэн байна. Харин 1961 онд Төв, Өмнөд бүсүүдийг нэгтгэсэн юм. Зүүн бүсэд Бээжин, Шанхай, Тяньжинь хот, Хэбэй, Жянсү, Жэжян, Фужянь, Шандун, Гуандун, Хайнань муж; Төвийн бүсэд Шаньси, Аньхуй, Жянси, Хэнань, Хубэй, Хунань муж; Баруун бүсэд Өвөр Монгол болон Гуанши-Жуаны өөртөө засах орон, Чунчин хот, Сычуань, Гүйжөү, Юньнань, муж, Төвөдийн өөртөө засах орон, Шаньси, Ганьсү, Хөх нуур муж, Нинша-Хотон болон Шинжаан-Уйгурын өөртөө засах орон; Зүүн хойд бүсэд Ляонин, Жилин, Хар мөрөн муж багтдаг. Хүн ам, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр Зүүн бүс нь тэргүүлэх байр суурьтай, Хятадын хөгжлийн гол цөм болж байхад Баруун бүсийн онцлог том нутаг дэвсгэр болно. Мөн чөлөөт худалдааны 14, өндөр технологийн 53, шинжлэх ухаан-технологийн 70 гаруй, экспортын бүтээгдэхүүн боловсруулах 38, эдийн засгийн дөрвөн тусгай бүс бий.

Засаг захиргааны I түвшний нэгж нь 22 муж, таван өөртөө засах орон (Өвөр Монгол, Гуанши-Жуань, Нинша-Хотон, Шинжаан-Уйгур, Төвөд), улсын чанартай дөрвөн хот, засаг захиргааны хоёр тусгай район (Хонконг, Макао) ба доошлоод аймаг, хошуу, сум, гацаа гээд ерөнхийдөө таван шатлалт тогтолцоотой.

Зураг 7. БНХАУ-ын эдийн засгийн бүсчлэл



Эх сурвалж: Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр, 2019

“...Бүс нутаг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилтэй давхцаж эсвэл хэд хэдэн нэгжийг нэгтгэсэн байж болно. Харин хуулийн этгээд гэдэгт зөвхөн ОХУ-ын тодорхой субъектийг ойлгоно”

*ОХУ-ын Бүсчлэлийн бодлогын
Үндсэн чиглэлээс*

Оросын Холбооны Улс

ОХУ асар том газар нутаг, байгалийн баялгийн их нөөцтэй. Эдийн засгийн хөгжлийн бүсчлэл тогтоохдоо газарзүйн байршилд тулгуурласан хуульчлан тогтоосон 11 макро бүстэй ба эдгээрт:

1. Төв бүс; 2. Төв хар хөрст бүс; 3. Дорнод Сибирийн бүс; 4. Алс Дорнодын бүс; 5. Умард бүс; 6. Умард Кавказын бүс; 7. Баруун хойд бүс; 8. Поволжийн бүс; 9. Уралын бүс; 10. Волго-Вятийн бүс; 11. Баруун Сибирийн бүс харин Калининград мужийг эдийн засгийн онцгой район хэмээн зарлажээ. Крымын бүгд найрамдах улс, холбооны статустай Севастополь хот одоогоор аль ч бүсэд хамаардаггүй. Түүнчлэн ерөнхийлөгчийн засаглал, цэрэг-стратегийн бодлогын үүднээс тогтоосон холбооны найман тойрог, цэргийн таван тойрог бий. Тус улс орон зайн хөгжлийн бодлогоо дараах макро бүсүүдээр төлөвлөн хэрэгжүүлж байна:

Харин засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагыг 22 бүгд найрамдах улс, 9 хязгаар, 46 муж, холбооны статустай гурван хот (Москва, Санкт-Петербург, Севастополь), Еврейн автономит муж, дөрвөн автономит тойрог (Ненецийн, Ханты-Мансийскийн, Чукотын, Ямало-Ненецийн) гэсэн холбооны 85 субъектээр дамжуулан хэрэгжүүлдэг.

Зураг 8. ОХУ-ын эдийн засгийн бүсчлэл





Бүгд Найрамдах Казахстан улс

1996 онд Засгийн газраас нь баталсан тус улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д бүс нутгийн хөгжлийн бодлогын зорилгоо “нутаг дэвсгэрийн зохистой хөдөлмөрийн хуваарь, бүсүүдийн төрөлжилт, хоршилтыг дэмжин зохицуулах үндсэн дээр бүс бүрийн байгалийн болон үйлдвэрлэлийн нөөцийг үндэсний эрх ашгийн үүднээс үр дүнтэй ашиглах, хүн амын амьдралын харьцангуй тэнцүү боломж бүрдүүлэх” хэмээн томъёолжээ. Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг үндэсний хөгжлийн стратегийн бүрэлдэхүүн хэсэг болгон томъёолохдоо байгаль, уур амьсгал, байршил, газарзүйн онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд цаашид төрөлжих хандлага, дэд бүтцийн тухайн үеийн болон ирээдүйд бий болгохоор төлөвлөж буй сүлжээ, коридор, хот суурины тогтолцоо, бүсүүд хоорондоо хамтран ажиллах чиглэл хийгээд бүс нутгийн шинжлэх ухааны ололт, бусад орны туршлага, сургамжийг харгалзан үзжээ.

Мөн хөрш бүс нутгийн интеграцид нэгдэх хүрээнд ойр дөт байрлал хийгээд уламжлалт харилцаандаа үндэслэн Урал, Сибирь, Повольже, Алтай, Дундад Азитай хамтын ажиллагааг хөгжүүлэх ихээхэн ирээдүйтэй гэж тооцож байна.

БНКУ 1996 онд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа баталсан. Эдийн засгийн таван бүстэй.

Зураг 9. БНКУ-ын эдийн засгийн бүсчлэл



Эх сурвалж: Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр, 2019

Монгол Улсын нутаг дэвсгэр өргөргийн дагуу баруунаас зүүн тийш цагийн гурван бүсэд сунаж оршдог. Мөн хойноос урагшаа ойт хээр, хээр, говь, цөлийн гэсэн байгалийн дөрвөн бүстэй.

Бүсчлэлийн схемийг оновчтой сонгож тогтоох нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэл хийх суурь нөхцөл, урьдач нөхцөл болох учиртай.

БҮС, ОРОН НУТГИЙН ЧАДАВХАД ТУЛГУУРЛАСАН ХӨГЖИЛ

Нутаг дэвсгэрээ эзэнтэй байлгах үндэсний эрх ашиг, уугуул нутагтаа тав тухтай амьдрах иргэний эрх ашиг, эх орныхоо аль дуртай газраа сонгон амьдрах хүний эрх гэж бий. Энэ гурван эрх ашгийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хангахдаа гол зарчим нь нутаг дэвсгэрийн хэмжээнд амьдралын харьцангуй ойролцоо нөхцөл бүрдүүлэх явдал бөгөөд үүнийг эдийн засгийн бүсчлэл тогтоох аргаар шийдэж буй улс орнуудын туршлага байна.

Монгол орны бүсчилсэн хөгжилд газарзүй, байр зүй, хүн ам зүйн хүчин зүйлс, дэд бүтцийн үндсэн суурь сүлжээ нэн чухал нөлөөтэй.

1992 онд баталсан Үндсэн хуульдаа “...бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх...”-ээр заасан нь нийгэм-эдийн засгийн шинэ харилцааны нөхцөлд төрөөс баримтлах бодлогын эрх зүйн үндэс болсон юм. Эдийн засгийн бүсчлэл гэж нутаг дэвсгэрийг дотоод зах зээл хөгжих, гадаад зах зээлтэй холбох газарзүйн байрлалын боломж, аймаг, сумдын аж ахуй, соёлын уламжлалт харилцаа холбоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтын нийтлэг байдал, байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээгээр бүрэн зохистой хоршин ашиглах боломж зэргээр нь бүсүүд болгон зохион байгуулж, эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийг энэ хүрээгээр зохицуулах үйл ажиллагааг илэрхийлдэг.

Эдийн засгийн бүсчлэлийг газарзүйн онцлогтой уялдуулах нь чухал ач холбогдолтой. Монгол орон хойноосоо урагш ойт хээр, хээр, говь, цөлийн гэсэн өргөргийн дөрвөн бүс, тайгын болон тагийн хоёр бүслүүртэй. Энэхүү байгалийн бүс, бүслүүр, гадаргын байдлаас хамааран Хангай, Хэнтий, Алтайн уулархаг, Дорнодын талархаг, Говийн цөлөрхөг дөрвөн их мужид хуваагддаг. Өнөөг хүртэл эдийн засгийн бүсчлэлийн аль ч схемд эдгээр бүс, бүслүүрийг багтааж ирсэн. Үүний ач холбогдол уур амьсгалын өөрчлөлт, хур тунадас, хадлан бэлчээрийн ургацын байдалд аж ахуйг уян хатан зохицуулах боломж олгодогт оршиж байв.


Манай улсын эдийн засгийн бүсүүдийн хувьд илэрхий тод ялгарах онцлог багатай, нийтлэг шинж давамгайлж байгаа ч тус бүрдээ өвөрмөц харьцангуй давуу болон сул тал, хүндрэл бэрхшээл, ойрын ирээдүйд тулгарч болзошгүй эрсдэлийг агуулж байдаг.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг төлөвлөх хүрээнд үндэсний орон зайн төлөвлөлтийг системчлэхдээ,

- байгаль, газарзүй, уур амьсгалын онцлог, ландшафт судлал;
- эдийн засаг, нийгмийн харилцаа;
- улс төр, засаглал, геополитик;



Зураг 10. Бүс нутгийн онцлог



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар, 2019

- түүх, соёл, уламжлал;
- функционал буюу чиг үүргийн хүчин зүйлс;
- нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалт

гэсэн судалгааны зургаан хүрээгээр нарийвчлан шинжилж, макро эдийн засгийн өнгөрсөн хугацааны үндсэн үзүүлэлтүүдийн тоон мэдээ, нийгэм, эдийн засгийн салбаруудын орон зайн дата буюу байгалийн нөөц, газрын даац, эдийн засгийн коридор, нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн байршил гэх мэт мэдээллүүдийг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр эдийн засгийн макро, микро бүс, тэдгээрийн таталцлын болон харилцан хамаарлын төвүүдийг тодорхойлох судалгаа, тооцооллыг хийсэн юм.

Эдийн засгийн макро, микро бүсүүд, тэдгээрийн таталцлын төвүүдийг тодорхойлж, хөгжлийн бодлого, дэмжлэгийг зохицуулснаар салбар хоорондын уялдаа, бүсүүдийн хоршилт, төрөлжилтийг дэмжих, байгалийн нөөц, чадавхыг эдийн засгийн өсөлт, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах, нэмүү өртгийн сүлжээ, кластер, үйлдвэрлэлийн бүсийг байгуулах, дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгүүдтэй холбогдох тээвэр-логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээг жишиг нормативт нийцүүлэн хүргэх, орон нутгийн хөрөнгө оруулалтын оновчтой төлөвлөлт хийх, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тогтворжуулж төвлөрлийг сааруулах боломж бүрдэх юм.

Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэхийн зорилго нь газарзүйн байрлал, байгалийн нөхцөл нөөц, хүн ам зүйн үзүүлэлтүүд, эдийн засаг нийгмийн хөгжлийн түвшин, бүтээгдэхүүн үйлдвэрлэл борлуулалтын нутаг дэвсгэрийн ялгааг багасгаж улмаар хөгжлийн өндөр түвшинд хүргэж чадах бие даасан чадамжийг бүрдүүлэхэд оршино.


Зураг 11. Монгол Улсын эдийн засгийн микро бүсчлэлийн хувилбар





МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН МИКРО БҮСЧЛЭЛИЙН ХУВИЛБАР

Масштаб 1 : 6000000



Эдийн засгийн микро бүс, тэдгээрийн таталцлын төвийг хүн амын тоо, түүний цэвэр өсөлт, механик өөрчлөлт болон нийгмийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ, бусад үзүүлэлтүүдэд тулгуурлаж тооцсон. Бүсчилсэн хөгжлийн тооцоогоор одоогийн засаг захиргааны нэгж болох 330 сум нэгэн зэрэг жигд хөгжих боломжгүй бөгөөд микро бүсийн төвүүд түлхүү хөгжиж, сум дундын тээвэр-логистикийн үйлчилгээг хангах боломжтой юм.

Эх сурвалж: Эдийн засаг, Хөгжлийн яам, 2022

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

ДЭД БҮТЭЦ

ЗОРИЛТ 8.1 Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030


Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбох үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр хөрш орнууд болон олон улсын эдийн засгийн интеграцад бүрэн холбогдох үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Орчин үеийн ухаалаг дэд бүтцийн сүлжээгээр эдийн засгийн хөгжлийг тэтгэх үе



Улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурь нөхцөл, хүн ардын амьдралын чанар дэд бүтцийн хөгжлөөс шууд хамаарна. Дэд бүтцийн хөгжил нь нутаг дэвсгэрийн байршил, бүсчлэлийн бодлоготой уялдсанаар бодит төлөвлөлт болдог. Иймд дэд бүтцийн хөгжлийн зорилтыг бүс, орон нутгийн хөгжилтэй уялдуулах учиртай.

Улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх үндсэн нөхцөл нь тогтвортой хөгжсөн, шинжлэх ухаан технологийн ололтод тулгуурласан дэд бүтцийн тогтолцоо байна. Улс орны хязгаарлагдмал төсөв, хуримтлалын хүрээнд нийгэм-эдийн засгийн төрөл бүрийн үйл ажиллагааг дэмжих үр ашигтай дэд бүтцийг хөгжүүлэх нь Монгол Улсын үндэсний хөгжлийн чухал асуудал юм.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, бүс, орон нутгийн хөгжлийг дэмжихэд орон нутгийг хот, суурины зах зээлд холбох дэд бүтцийг барьж байгуулах, бизнес эрхлэх боломжийг дээшлүүлэх, орон нутгийн давуу талд тулгуурлан ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Мөн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын өрсөлдөх чадварыг дэмжсэн, нэмүү өртөг илүү шингээхэд дэд бүтцийн хөгжил үндэс, суурь нь болно.

Монгол Улс “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан-2019”-д дэд бүтцийн үзүүлэлтээр 62 дугаарт эрэмбэлэгдсэн нь манай улсад дэд бүтцийн шинэчлэл, тэлэлт, шинэ бүтээн байгуулалтыг



Зураг 12. Зам тээврийн дэд бүтцийн сүлжээ



Эх сурвалж: Зам, Тээврийн Хөгжлийн Яам, 2022

эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байгаа юм. Монгол Улсад өрнөх бүтээн байгуулалтын тодорхой зорилгот хэсэг нь зайлшгүй БНХАУ, ОХУ-ын хил залгаа шинэ бүтээн байгуулалтыг угтуулан тавих замаар хөгжих учиртай. Өнөөдрийн байдлаар манай улсын дэд бүтэц стратегийн орд газруудыг өмнөд хөрштэй холбосон, БНХАУ-ын түүхий эдийн ханган нийлүүлэлтийн бүтэц болоод байна. Иймд цаашид дэд бүтцийн тэлэлтийг өмнөд, хойд хөрштэй холбосон, транзит байдлаар төлөвлөж, бүтээн байгуулах нь чухал зорилт болж байна.

Засгийн газраас авто зам, төмөр зам, болон стратегийн орд газруудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхээр ажиллаж буй. Тэдгээрээс дурдвал Хөшигийн хөндий, Говьсүмбэрийн Баянталд эдийн засгийн чөлөөт бүс, карго логистикийн төв байгуулах, Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бүсийг барьж дуусгах, Хавирга, Гашуунсухайт, Шивээ хүрэн, Булган, Боршоо, Арц суурь, Бага Илэнх зэрэг хилийн боомтуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх, Хөгжлийн ирээдүйтэй суурин газарт бүс нутгийн онцлог, нүүдлийн мал аж ахуйд тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн 33 паркийг байгуулах, орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын

Олон улсын тээвэр логистикийн гурван төв, бүсийн тээвэр логистикийн зургаа, орон нутгийн тээвэр логистикийн 33 төвийг байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 2. Монгол Улсын ачаа тээвэрлэлт

	1990	1995	2000	2005	2010	2015	2020	2021
Сая тонн/километр								
Нийт	6,971.6	2,437.1	4,418.3	10,267.7	12,124.8	13,844.3	23,861	20,674.56
Төмөр зам	5,087.8	2,279.5	4,282.5	9,947.7	10,286.7	11,462.6	19,167.6	18,345.08
Авто зам	1,870.9	152.9	126.1	311.0	1,834.0	2,374.0	4,685.3	2,313.92
Агаарын тээвэр	8.0	4.5	9.4	8.9	4.2	7.7	8.1	15.56
Усан тээвэр	4.9	0.2	0.3	0.1				
Мянган тонн								
Нийт	54,038.5	8,950.8	10,643.4	23,670.5	29,415.9	32,197.3	60,297.76	49,238.09
Төмөр зам	14,517.1	7,298.0	9,158.5	15,586.3	16,804.0	19,150.8	29,840.06	31,261.36
Авто зам	39,438.9	1,648.5	1,480.4	8,081.7	12,610.2	13,043.7	30,454.96	17,970.3
Агаарын тээвэр	10.9	2.7	2.9	2.0	1.6	2.8	2.74	6.43
Усан тээвэр	71.6	1.6	1.6	0.5				

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2022

Дэд бүтэц бол нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжиж, идэвхжүүлдэг систем, сүлжээний хэрэгслүүд, байгууламж болон бусад биет зүйлсийг хэлэх бөгөөд эдгээр нь бүс нутаг, байгууллага, хүмүүсийг холбож, тэдний харилцан уялдаа холбоо, хамтын ажиллагаа, итгэлцэл, түншлэлийг хангах ба энэхүү харилцаа холбооны байнгын тасралгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангана.

аюулаас амжиж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг 18 аймаг, аюулын эрсдэл өндөртэй 13 суманд байгуулах гэх мэт зорилтыг тодорхойлсон билээ.

Мөн эдийн засгийн өсөлтийг дэмжих, ялангуяа иргэд, нийгмийн бүх хүрээний амьдралын чанарыг сайжруулж, хүртээмжтэй нийгэм байгуулахад цахилгаан, дулаан хангамж, ус болон цэвэрлэх байгууламжаар хангах инженерийн дэд бүтцийн үүрэг их. Инженерийн дэд бүтцийн хөгжлийн бодлогыг хот болон орон нутгийн гэсэн тодорхой заагтайгаар тодорхойлох шаардлага үүсэж байна. Ялангуяа хөдөөнөөс Улаанбаатар хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас олон иргэд инженерийн үндсэн дэд бүтэцгүй хотын захын гэр хороололд амьдарсаар байна. Тиймээс дэд бүтцийн хөгжлийн стратеги нь тухайн хот, бүс, орон нутагт тохирсон, олон төрөл байх шаардлагатай.

Иймд сумын төвүүдэд иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөл, хөгжих боломж бололцоог бүрдүүлэх замаар хүн амын Улаанбаатар хот болон төв суурин газар руу шилжих хөдөлгөөний суурь шалтгааныг өөрчлөхөөр ажиллаж байна. Уг зорилтын хүрээнд Засгийн газраас “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төслийг үе шаттай хэрэгжүүлж байна. Иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэрлэх, дулаан, хэрэгцээний халуун устай болгох, сумын төвийн орон сууц, худалдаа, үйлчилгээний зэрэг барилга байгууламж, айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээтэй болгохоор зорьж байна.



Дэлхийн дэд бүтцийн салбар коронавирус цар тахлын улмаас томоохон сорилтод орж, зөвхөн 2020 онд энэ чиглэлийн хөрөнгө оруулалт хагас их наяд ам.доллараар буурсан. Давосын чуулга уулзалтын үеэр энэ сэдэв хамгийн том хэлэлцүүлэг байсан бөгөөд дэд бүтцийн салбарт шинээр гарч ирж байгаа технологи, инновацыг нэвтрүүлэх, уламжлалт арга барилыг өөрчилж, аюулгүй байдлыг сайжруулах, декарбонизацыг хурдасгах, бүтээн байгуулалтын үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, дэд бүтцийн системийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг оновчтой болгохын тулд дэд бүтцийн салбарт инфратех технологийг илүү өргөнөөр ашиглахаар болж байна. АНУ дэд бүтцийн салбарт тогтвортой дэд бүтцийн бодлогыг хөгжүүлэх бол Европын холбоо, БНХАУ ногоон дэд бүтцийн хөгжлийг чухалчлахаа зарласан.

Түүнчлэн дэлхий нийтийн дэд бүтцийн салбарт гойд анхаарч байгаа нэг сэдэв бол олонх хүнд нийгмийн шинж чанартай мэт санагдах атал бодит байдал дээр арьс өнгөөр ялгаварлах үзэл дэд бүтцийн холболтод ч далд хэлбэрээр нөлөө үзүүлж байгаа тухай юм. Учир нь, АНУ-ын хуучин дэд бүтцийн суурийг судалж үзэхэд өнөөдрийг хүртэл үргэлжилсэн систем нь ялгаварлан гадуурхах үзэлтэй нягт холбоотой байсан нь тогтоогдсон тул энэ нь дэлхийн улс орнуудад сургамж болж, дэд бүтэц, үйлчилгээ хүн амын аль ч хэсэг тэгш, хүртээмжтэй байх ёстой болохыг харуулж байна.

Монгол Улсын хэмжээнд дэд бүтцийн шинэчлэл, хөгжлийн бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь ийнхүү тэгш хөгжих, эрх тэгш амьдрах орчин нөхцөлийг хангах зорилттой нягт уялдаатай.

БҮСИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖИЛ

Бүс нутгуудад логистикийн сүлжээг хөгжүүлэх нь аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх чухал хөшүүрэг юм. Тиймээс үйлдвэрлэл бүхий газруудын тархалтад үндэслэн бүс нутгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх замуудыг тавих нь нэн тэргүүнд байх нь зүйтэй. Бүсийн авто замын сүлжээг авто замын гол сүлжээтэй холбосноор эдийн засгийг төрөлжүүлэхэд ач холбогдолтой.

Монгол Улсын Авто замын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2021 оны байдлаар 111,916.7 км байгаагийн 99,891.2 км нь буюу 89.2 хувь нь ердийн хөрсөн, 12,025.5 км буюу 10.8 хувь нь сайжруулсан зам байна. Нийт сайжруулсан замын 10,243.8 км буюу 85.1 хувийг хатуу хучилттай, 1176.79 км буюу 9.8 хувийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5.1 хувийг сайжруулсан хөрсөн

Бүс нутгийн шинжлэх ухаан нь байгаль, нийгмийн юмс, үзэгдэл, тэдгээрийн нөхцөл, нөөцийн орон зайн тархалт, байршил буюу нутаг дэвсгэрийн системүүдийн харилцан хамаарал, орон зай, цаг хугацааны өөрчлөлт, тэдгээрийн ашиглалт, хөгжил төлөвлөлт зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамран судалдаг.


Төмөр зам, авто замаар тээвэрлэх, экспортлох ачааны хэмжээг 80-90 сая тоннд хүргэхээр дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

зам эзэлж байна. Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14,918.7 км буюу 13.3 хувь, орон нутгийн чанартай зам 96,125.3 км буюу 85.9 хувь, уул уурхайн буюу тусгай зориулалттай зам 898.4 км буюу 0.8 хувийг эзэлж байна. Авто тээврээр 2021 онд 17.9 сая тонн ачаа тээвэрлэгджээ. Энэ нь өмнөх оныхоос 12.48 сая тонн буюу 41 хувиар буурсан байна. Авто тээврээр ачааны импортын 81 хувийг Замын-Үүд эзэлдэг бол экспортын 48 хувийг Гашуунсухайт, 28 хувийг Шивээхүрэн, 10 хувийг Ханги боомтууд тус тус эзэлж байна.

ЖАЙКА-ийн Төслийн баг Монгол Улсын замын хөдөлгөөний эрчмийн судалгааг хүн амын өсөлт, ДНБ-ний өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт зэрэг хүчин зүйлсээс хамааран сүүлийн 10 жилийн хугацааны өсөлтийн чиг хандлагад дүн шинжилгээ хийж, тус дүн шинжилгээнд үндэслэн замын хөдөлгөөний эрчмийн их, бага хувилбарыг тодорхойлсон байна. Авто замын сүлжээг цаашид хөгжүүлэх хэрэгцээ шаардлагын хувьд замын нэвтрүүлэх хүчин чадал болон замын хөдөлгөөний ачааллын харьцааг (VCR) зарим замуудаар тооцож, зорилтот онуудаар 2025, 2030, 2040 үнэлж, төмөр замын бүтээн байгуулалт, уул уурхайн үйлдвэрлэл, хил орчмын худалдааны өсөлтийг тусгасан байна.

Замын хөдөлгөөний эрчим нэмэгдэж байгаа ба авто замын тээвэр нь Монгол Улсын хамгийн чухал тээврийн төрөл хэвээр байх тул нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд авто замын гол сүлжээг шинэчлэх, сүлжээ болон аймаг хоорондын авто замыг хөгжүүлж, сайжруулах шаардлагатай. Энэ нь аймаг, сумдын

Зураг 13. Замын хөдөлгөөний эрчмийн үнэлгээний үр дүн (их байх хувилбараар)



Үндсэн нөхцөл байдал (2019 он) Тээврийн хэрэгсэл тоо/өдрөөр

2025 он Тээврийн хэрэгсэл тоо/өдрөөр



хөгжилд төдийгүй эдийн засгийн салбаруудыг (аялал жуулчлал, худалдаа, уул уурхай г.м.) хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.


Иймд бүсийн эдийн засгийг төрөлжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаатай байдлаар авто замын сүлжээг хөгжүүлж, аж үйлдвэрийн кластерын хөгжлийг дэмжинэ. Бүсийн авто замын босоо тэнхлэг нь хойд, урд хөрш улсуудыг холбосон транзит замууд байх бөгөөд энэхүү гол магистралаас үйлдвэрлэл бүхий байршлууд, боловсруулах үйлдвэрүүд, хот, суурингуудыг болон экспортын зах зээлтэй холбоно.

Мөн аймаг, сумдын Монгол Улсын эдийн засагт оруулж болох хувь нэмэр, орон нутгийн хөгжлийг бүтэн зургаар нь харж, бүс нутгуудад дэд бүтцийг хөгжүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн билээ. Тухайлбал,


- Хөндлөн тэнхлэгийн гол зам болон хойд, урд хөршийг холбосон босоо тэнхлэгийн авто замуудыг барьж бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэх;
- Хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, босоо, хөндлөн гол тэнхлэгийн авто замын сүлжээтэй үе шаттайгаар холбох, бүс нутгийн онцлог, нүүдлийн мал аж ахуйд тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн 33 паркийг бүсчлэн байгуулах;
- “Тавантолгой”–“Зүүнбаян”, “Зүүнбаян”–“Ханги”, “Нарийн сухайт”–“Шивээ хүрэн”, “Тавантолгой”–“Гашуунсухайт”, “Сайншанд”–“Баруун-Урт”–“Хөөг” зэрэг стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлэх;

“Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор”

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг өрсөлдөх чадвараар хангах, хил дамнан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор “Гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг 2016 онд Ташкент хотноо баталгаажуулсан. Хөтөлбөрийн хүрээнд тээврийн дэд бүтэц буюу авто зам, төмөр замын, аж үйлдвэрийн, хилийн боомтыг шинэчлэх болон эрчим хүч, худалдаа, гааль, мэргэжлийн хяналт, хорио цээр, хүрээлэн буй орчин, шинжлэх ухаан, технолог, хүмүүнлэг, хөдөө аж ахуй, анагаах ухаан, эрүүл мэндийн зэрэг олон салбарт хамтран ажиллахаар тохиролцсон.



2030 Тээврийн хэрэгсэл тоо/өдрөөр



2040 Тээврийн хэрэгсэл тоо/өдрөөр

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн газар, Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), 2021

Бүс нутгууд тус тусын өвөрмөц онцлог, эдийн засгийн төрөлжилтөөр хөгжиж, харилцан уялдах, илүү, дутуугаа нөхөх, солилцоход тээвэр логистикийн хөгжил ихээхэн чухал юм.

- Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулах;
- Бүх сууринг улсын болон бүсийн чанартай авто замтай холбох
- Хүн ам төвлөрсөн эдийн засгийн таталцлын төвүүдийг төмөр замын сүлжээнд холбох;
- Хэрэглэгч бүрд хүрсэн орчин үеийн ухаалаг тээвэр логистикийн сүлжээг нэвтрүүлэх зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заасан.

Дээрх зорилтын хүрээнд зам, тээвэр, логистикийн дэд бүтцийн хөгжлийг хангах төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. Тухайлбал,

- Улсын чанартай хөндлөн гол, таван босоо тэнхлэгийн авто замууд, баруун босоо тэнхлэгийн төмөр замыг үе шаттайгаар барьж байгуулах;





- Орон нутгийн чанартай авто замуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэн, сайжруулах;
- Түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалт, экспортын зах зээлийг холбосон авто замыг барьж байгуулан, үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Транзит тээвэр, экспортыг нэмэгдүүлэх төмөр замын шугамыг барьж байгуулах, хилийн боомтын дэд бүтцийг сайжруулах;
- Хот, хоорондын агаарын тээврийн үйлчилгээг хөгжүүлэх
- Аялал жуулчлалын гол бүс нутгийн авто зам, дэд бүтцийг хөгжүүлэх сайжруулах;
- Төмөр замын тээврээр зорчих зорчигчдын тоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх үүднээс хөдөө орон нутгийн авто замыг сайжруулах чиглэлээр төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.



Хүн ам, нөөц, бараа бүтээгдэхүүн болон мэдээллийг хурдан, үр дүнтэй, найдвартай солилцох, ус болон цахилгаан, дулааны найдвартай эх үүсвэрээр хангах, хог хаягдлыг боловсруулах, хүний хөгжлийг хангах, дэмжих хамгаалах, олон талт соёлтой, дэвшилтэт нийгмийг бий болгоход дэд бүтцийн хөгжлийн үүрэг, зорилго оршино.

Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг 3-4 дахин нэмэгдүүлнэ.


ХИЛИЙН БООМТ

Тээврийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэхэд замын сүлжээнээс гадна түүнд үйлчлэх логикийн тогтолцооны төлөвлөлт онцгой чухал. Энэ нь улс дамнасан эдийн засгийн коридор болон үндэсний эдийн засгийн төвлөрсөн том байршлууд, орон нутгийн бүсүүдэд үйлчлэх зорилгоор олон төрөлт тээврийн уялдааг хангах чиглэлээр хөгжих шаардлагатай. Логистикийг хөгжүүлэхийн зэрэгцээ улс хоорондын гаалийн хяналтын тогтолцоо, дэд бүтцийн хөгжлийг дэмжих хэрэгтэй юм.

Монгол Улс нь өргөн уудам газар нутагтай, хүн ам нь тархай бутархай суурьшсан, хилийн шугам урттай орон юм. Тээврийн нягтрал бага учраас ихэнх хилийн боомт 24 цагаар ажилладаггүй, үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байдаг.

Монгол Улс нь ОХУ болон БНХАУ-тай хиллэдэг, хилийн шугамын нийт урт 8,252.6 км, үүнээс хуурай газрын хилийн урт 7,351.6 км, усан хилийн урт 901 км, агаарын замын зургаа, төмөр замын зургаа, авто замын хорин найман боомт байна. Монгол-Оросын хилийн дагуух 16 боомттой хиллэж байгаа бөгөөд тэдгээрийн зургаа нь олон улсын зэрэглэлтэй, долоо нь хоёр талын зэрэглэлтэй, нэг нь түр ажиллагаатай, нэг нь түр эсхүл улирлын ажиллагаатай, хоёр нь тогтмол бус ажиллагаатай дамжин өнгөрөх зориулалттай хилийн боомт байна. Эдгээр боомтуудын 14 нь

Зураг 14. Монгол Улсын хилийн боомтууд



Эх сурвалж: Монголын Эдийн засгийн Форум, 2022



автозамын, хоёр нь төмөр замын боомт юм. Харин Монгол-Хятадын хилийн дагуу нийт 17 боомттой хиллэж байгаа бөгөөд тэдгээрийн дөрөв нь олон улсын шинжтэй байнгын ажиллагаатай, нэг нь олон улсын шинжтэй түр ажиллагаатай, хоёр нь хоёр талын шинжтэй байнгын ажиллагаатай, зургаа нь хоёр талын шинжтэй түр ажиллагаатай байна. Эдгээрийн 13 нь авто замын, дөрөв нь төмөр замын боомт юм. Харин агаарын замын зургаан боомт байдаг бөгөөд Чингис хаан боомт хэвийн үйл ажиллагаа явуулж, Ховд, Өлгий, Чойбалсан боомтууд түр ажиллахгүй, Даланзадгад, Мөрөн боомтууд ажиллахгүй байна.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилт дэвшүүлсэн билээ.

Энэ хүрээнд:

- Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, байгуулах;
- Хавирга, Гашуунсухайт, Шивээ хүрэн, Булган, Боршоо, Арц суурь, Бага Илэнхи зэрэг хилийн боомтуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх;
- Ази, Европыг дамжсан олон улсын худалдаа-эдийн засгийн харилцааны гол гарц болж буй Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүдийн олон улсын хилийн боомт, улсын эдийн засгийг гадаад зах зээлтэй холбосон босоо тэнхлэгийн төмөр болон авто замын сүлжээг ашиглан Сибирийн байгалийн баялгийг БНХАУ-д нийлүүлэх тээвэрлэлтийг хөгжүүлэх;
- ОХУ-тай, БНХАУ-тай холбогдсон хилийн гол гарцыг авто болон төмөр замаар холбож, улс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Транзит тээвэр, экспортыг нэмэгдүүлэх хилийн боомтын дэд бүтцийг сайжруулахыг зорьж байна.

Монгол Улс болон ОХУ-ын төмөр замын царигийн өргөн 1,520 мм тул БНХАУ-ын төмөр замтай хил залгаа бүсүүдэд төмөр замаар тээвэрлэн хүргэсэн ачааг шилжүүлэн ачих шаардлагатай байдаг. Тээвэрлэлтийн явцад ачааг шилжүүлэн ачих нь нэмэлт цаг хугацаа, зардлыг шаарддаг. Иймд хилийн боомт дахь ачих, буулгах байгууламж барих, шинэ технологи, тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх төслүүдийг мөн хэрэгжүүлнэ.

Зураг 15. Ачаа тээврийн дэд бүтэц



Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан, эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулж худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар бүрэн холбож ачаа тээврийн урсгал, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ЗОРИЛТ 8.2 Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

II ҮЕ ШАТ | 2021-2030

Бүтээн байгуулалтын үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Эдийн засгийн харилцаа,
хамтын ажиллагааг хөгжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Бүс, орон нутаг эдийн засгийн
хувьд бие даан хөгжих үе

Газарзүйн байрлал, байгаль, түүх, түүхэн олдворууд, соёлын өв, нүүдлийн ахуйд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутгуудыг хөгжүүлж, дэд бүтэц, түүнийг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүний хөгжлийг эрчимжүүлэх, чанарыг сайжруулах, сурталчлан таниулах, олон улсын зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлнэ.


Аялал жуулчлалын салбар нь ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн боломжит салбар бөгөөд бусад чиглэлийн бүтээн байгуулалт, хөгжлийн дэд бүтэцтэй уялдаж хөгжихийн зэрэгцээ жуулчдын сэтгэл ханамж, оюун бодол, гоо зүйг мэдрэх мэдрэмж, үнэлэмж зэрэгтэй хамтдаа оршдог онцлогтой. Тиймээс ч аялал жуулчлалын хөгжлөөр дамжуулан байгалийн унаган төрх байдал, ард түмнийхээ зан заншлыг дэлхий нийтэд сурталчилж, хамгаалан хөгжүүлэх бодлогыг улс орон бүр өөрийн орны онцлог, газарзүйн өвөрмөц тогтоцод нийцүүлэн боловсруулдаг бөгөөд НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-аас 2018 онд аялал жуулчлал үйлдвэрлэл дэлхийн ДНБ-ний 10 хувьтай тэнцэж, барааны экспортын долоон хувь, үйлчилгээний экспортын 30 хувийг эзэлж, 10 хүн тутмын нэг нь энэ салбарт ажиллаж байгааг мэдээлсэн. Ингэснээр дэлхийн жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад гурав дахин нэмэгдэж 1.6 тэрбумд хүрсэн бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо хурдацтай нэмэгдэж буйг тогтоосон байдаг.

Аялал жуулчлалын салбар өсөлттэй байсан цаг хугацаанд буюу 2018 онд 529,400 жуулчин хүлээн авсан бөгөөд мөн оны





Зураг 16. Жуулчны сонирхол татдаг байршил



- | | | | | | |
|----|-----------------------|----|--------------|---|--------------------|
| + | Хиргэсүүр | ⊕ | Тахилгат уул | ⊙ | Үзэсгэлэнт газар |
| ⌄ | Буган хөшөө | ⬮ | Хүн чулуу | ★ | Цаатны отог |
| ▼ | Агуй | ⬆ | Рашаан | ● | Хадны бичээс |
| ⬆ | Хүүхдийн зуслан | ⌄ | Хийд | 🏠 | Эртний хотын туурь |
| ⬮ | Чингис хааны өв нутаг | 🏛️ | Музей | ⬆ | Бөөгийн оромж |
| ✳️ | Амралтын газар | 🏠 | Олдвор | 🏠 | Жуулчны бааз |

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн газар, Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), 2021

салбарын орлого 461 сая ам.доллар буюу ДНБ-ий дөрөв орчим хувьд хүрсэн байдаг.

Монгол Улсын соёл, түүхтэй танилцах боломжтой олон газар нутагт аялал жуулчлалын болон тээврийн дэд бүтэц хангалттай хөгжөөгүй байна. Ихэнх жуулчид богино хугацаанд жуулчилж, үзэсгэлэнт газруудаар аялах сонирхолтой байдаг тул эдийн засгийн үр ашиг нь тодорхой газруудад богино хугацаанд гарч байдаг.

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын мэдээлснээр шинээр дэлхий нийтэд танигдаж байгаа аялал жуулчлалын газруудад очих хүмүүсийн тоо жилд 4.4 хувиар өсөж 2010-2030 оны хооронд өндөр хөгжилтэй орнуудаас 2 дахин (жилд 2.2 хувь) нэмэгдэх төлөвтэй байна гэжээ. Монгол улс нь байгалийн өвөрмөц онцлог, хүний гар хүрээгүй онгон зэлүүд нутаг, нүүдэлчин ахуй, соёлын өв уламжлалаа сурталчлах замаар ардчилсан хувьсгалаас хойш соёл, нийгмийн өв уламжлалаа дахин сэргээж буй улс орны хувьд олон жуулчдыг татах боломжтой.

Испани, Япон, АНУ, Арабын Нэгдсэн Эмират Улс, БНХАУ зэрэг улс оронтой харьцуулахад манай улсын хүлээн авч буй жуулчдын тоо маш бага бөгөөд дээрх орнууд жилдээ 20-100 сая жуулчин хүлээж авдаг.



Аялал жуулчлалын салбарт цор ганц байдаг үйлчилгээг үзүүлэх, бүтээгдэхүүнийг борлуулах, дахин давтагдашгүй өөрийн онцлогтой аялал жуулчлалын түшиц газраар аялуулах нь амжилттай бизнесийн үндэс болох юм.


Нутгийн иргэд аялал жуулчлалыг урт хугацаанд хөгжүүлж чадах түншлэлийг эрэлхийлдэг болсон. Жуулчид ихэвчлэн хөндөгдөөгүй, зэрлэг онгон байгальтай газраар аялах илүү сонирхолтой байдаг байна. Зочид буудал, аялал жуулчлалын компаниуд хоорондоо өрсөлдөж байгаа ч тэдний санал болгож буй аялал жуулчлалын түшиц газар, бүтээгдэхүүн нь ижил тул дундын нөөц баялгаа хамтдаа хамгаалж, аялал жуулчлалын түшиц газрын тогтвортой байдлыг хангах нь нэн чухал.

Тус улсад зорин ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхийн тулд Монгол Улс аяллын визний нөхцөлөө хөнгөвчилж, олон улсын нислэгийн тийзний үнийг бууруулах, агаарын тээврийг либералчлах, олон улсын нислэгийн тоо, давтамж, чиглэлийг нэмэгдүүлснээр аялал жуулчлалын салбарын өсөлтийг хангах боломж бүрдэх юм.

Аялал жуулчлал нь Монголын ард иргэдийн өөрийн эх орноор бахархах сэтгэлийг бэхжүүлэх бол харин гадаадын жуулчид Монголын гайхамшигт байгаль, нүүдэлчин соёлыг мэдэрснээр Монголын сэтгэл татам байдлыг дахин үнэлэх гэсэн ач холбогдолтой.

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангахын тулд тэнцвэрийг алдагдуулахгүй байх, аливаа тодорхой бүс нутагт хэт их ачаалал өгөхөөс зайлсхийх зэрэг тодорхой зорилттойгоор аялал жуулчлалын чиглэлүүдийг судалж, шинээр үүсгэн бий болгох шаардлагатай.

Зураг 18. Гадаадын жуулчид, ирсэн улс, хувиар (2019)



Эх сурвалж: Байгаль орчин, Аялал жуулчлалын яам, 2022


АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮСЧЛЭЛ

Монгол бол дэлхий дээрх хамгийн анхны нүүдэлчин, бас одоо ч нүүдэлчин ахуйгаа хадгалж буй ганц орон гэж болно. Иймээс нүүдэлчин ахуйг газар дээр нь үзэх, онгон дагшин байгальд аялах, Монголын говьд нар мандахыг харах гэх мэт боломж гагцхүү Монголд байна.

Аялал жуулчлалын бүсийг орон нутгийн онцлогоор нь:

- Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэнт бүс;
- Олон ястны зан заншил, соёлын онцлог бүхий өндөр уулын бүсийн экосистемт бүс;
- Түүх соёлын үнэт дурсгалын бүс;
- Эх газрын өвөрмөц, онгон байгаль, палеонтологийн олдвор, ховор ан амьтан бүхий бүс;
- Чингис хааны түүхтэй холбоотой дурсгалт газрууд бүхий бүс;
- Улаанбаатар орчмын бүс гэж үндсэн зургаан хэсэгт хуваасан байдаг.

Зураг 19. Аялал, жуулчлалын бүсчлэл





Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэнт бүс

Хөвсгөл аймаг бүхэлдээ багтана. Монголын хамгийн их эзлэхүүнтэй, хамгийн гүн, далайн түвшнээс 1,645 метр өндөрт оршдог цэнгэг устай Хөвсгөл нуур болон уулархаг, уул, ус, ой, хөвч, тайга болсон байгалийн үзэсгэлэнт газар. Амьтан ургамал, ашигт малтмалаар баялаг, түүх, байгалийн дурсгалт газар арвинтай, онгон дагшин байгалийн өлгий болсон нутаг.

Олон ястны зан заншил, соёлын онцлог бүхий өндөр уулын экосистемт бүс

Энэ бүсэд Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай аймгуудын нутаг багтана. Иймд уг бүсийн Ховд, Улаангомын нисэх буудлыг 4С зэрэглэлтэй болгох юм. Монгол Алтайн сүрлэг уулс, Увс, Хар ус нуурын Их нууруудын хотгор багтдаг. Байгаль экологийн, тусгай сонирхлын аялал жуулчлал, Алтайн түүх, соёл, зан заншил, байгалийн өвөрмөц онцлогт түшиглэсэн хил дамнасан аялал жуулчлалыг хоёр хөрш улстай хамтран хөгжүүлэх бололцоотой.

Түүх соёлын үнэт дурсгалын бүс

Хүннүгийн түүхэнд холбогдох олдвол олдвор, булц, бунхан, түүнчлэн Их Монголын эзэнт гүрний нийслэл багтсан бүс нутаг. Өвөрхангай, Архангай гэх мэт дэд төвтэй байх боломжтой. Энэ бүсэд эртний Монгол Улс түүхэнд түшиглэсэн байгалийн, амралт, зугаалгын тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх юм. Түүнчлэн эртнээс манай өвөг дээдэс биеэ сувилж ирсэн Хужирт, Шаргалжуут, Хөнхөр зуслан, Улаанхайрхан, Аргалант зэрэг рашаан устай газруудад дотоодын аялал жуулчлал, сувиллын сүлжээг хөгжүүлнэ.

Эх газрын өвөрмөц, онгон байгаль, палеонтологийн олдвор, ховор ан амьтан бүхий бүс

Говийн бүс тэр чигтээ аялал жуулчлалын онцгой сонирхолтой нутаг. Нэмэгт, Хэрмэн цав, Бүгийн цав, Шар цав, Баянзагт түшиглэсэн палеонтологийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Говийн археологи, палеонтологийн асар баян өвийг эргэлтэд оруулна. Говийг сонирхон зорих жуулчдын тоо буурахгүй. Монгол орны хамгийн нандин бас эмзэг байгалийн тогтоцтой энэ бүс нутагт дэлхийд ховордсон мазаалай, бөхөн, хавтгай, хулан зэрэг нэн ховор амьтад нутагладаг нь жуулчид, амьтан ургамал сонирхогчдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Байгалийн өвөрмөц сонин тогтоц, ховор нандин амьтны нутгийг түшиглэн үндэсний парк байгуулах боломжтой.

Хүмүүс амрах, адал явдал хайх, энэрэн туслах, шинэ зүйлийг нээх гэх мэт олон зорилгоор аялдаг. Монгол Улсад түүх археологийн, соёл заншлын, загасчлал тэргүүтэй байгалийн, шашны болон уул, тал, говь цөлийн адал явдалт гэх зэрэг аялал жуулчлалын өргөн боломж бий.



Баянхонгор аймгийн алдарт Их Богд уулын бүсэд байгуулагдсан **ЭКО ОТОГЛОХ ЦЭГ**:


Жуулчид очоод тухлан саатахдаа дараагийн хүний төлөө цэвэрхэн, ариг гамтай, хэрэглэх нь чухал.

Чингис хааны түүхтэй холбоотой дурсгалт газрууд бүхий бүс
Энэ бүсэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд багтаж байна. Энэ нь бүсийн гол онцлог нь Чингис хааны түүх билээ. Сүүлийн жилүүдэд зүүн тийш дотоодын жуулчлалын урсгал нэмэгдэх болсон нь энэ салбарыг хөгжүүлэх таатай хөрс суурь юм.

Улаанбаатар орчмын бүс нутаг

Ихэнх жуулчин хөдөө орон нутаг руу аялахаасаа өмнө Улаанбаатар хотоор дамждаг. Иймд Улаанбаатар хот орчмын бүсэд аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн түүх, соёл, байгалийн тусгай сонирхлын аяллаас гадна ажил хэргийн бизнес, шинжлэх ухааны бүс болгон хөгжүүлнэ. Аялал жуулчлалын бүсүүдийг дагасан брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, нүүдэлчдийн төв нутаг болохынхоо хувьд наад зах нь монгол туургатнуудынхаа хэмжээнд наадам зэрэг монгол өв соёл, ёс заншилд түшиглэсэн эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

Зураг 20. Түр саатах, амрах үйлчилгээний байгууламжуудыг төлөвлөсөн байршил



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн газар, Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), 2021




ШИНЭ ЖУУЛЧИД БУЮУ ДОТООДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд аялал жуулчлал, жуулчин гэхтэй зэрэгцэн зөвхөн гадаад хүн, гадаад орны иргэд Монгол Улсаар аялж жуулчлах тухай төсөөлдөг байсан. Харин сүүлийн жилүүдэд дотоодын аялал жуулчлал эрчимтэй нэмэгдэх болсон. Энэ нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын бааз, үйлчилгээний төвүүдэд ихээхэн дэмжлэг болсон бөгөөд албан бус мэдээллээс үзэхэд Баян-Өлгий аймаг гэхэд 2019 онд 13 мянган жуулчин хүлээн авсан бол энэ тоо 2020 онд 25 мянга болж өссөн байна. Ингэснээр орон нутгийн эдийн засагт дөрөв орчим тэрбум төгрөгийн орлого орж, хүнсний худалдааны орлого нь өмнөх оныхоос хоёр дахин нэмэгдсэн байна.

Дорнод аймгийн Буйр нуур орчимд үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын орлого мөн хоёр дахин нэмэгдсэн бол Дундговийн Цагаан суваргад 2020 онд гэхэд жилдээ 20 мянган дотоодын аялагч зорин очжээ. Эндээс үзэхэд дотоодын аялал жуулчлалыг дэмжих нь эрсдэл багатайн дээр найдвартай аялал жуулчлалд тооцогдохоос гадна улс эх орныхоо түүх, соёлыг танин мэдэж, байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцах замаар эх оронч монгол иргэнийг төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Зураг 21. Дотоодын жуулчдын тоо, аймгаар (2019)



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн газар, Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), 2021

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ

ЗОРИЛТ 8.3 Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Хөдөө аж ахуйн нөөцийг бүрэн ашиглах, тогтвортой үйлдвэрлэл, үр ашиг, бүтээмжээр өрсөлдөх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

“Ухаалаг” хөдөө аж ахуйг хөгжүүлэх үе



Хөдөө аж ахуй нь гаршуулсан амьтан болон ургамлыг тодорхой зохион байгуулалттайгаар өсгөн үржүүлэх замаар хүнс, тэжээл, цагдуул болон бусад бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх үйл явц бөгөөд Монголчуудын хүнсний хэрэглээ, бүс нутгийн сэргэлт, эдийн засгийн өсөн нэмэгдэх чадавхад хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжил, шинэчлэлийн бодлого нэн тэргүүнд тавигдаж байна.

Хөдөө аж ахуй бол байгаль орчин, эдийн засаг, нийгмийн дэд системүүдээс бүрдэх нийлмэл систем юм. Эдгээр дэд системүүдийн зохистой динамик харьцаа бүрдэж байж хөдөө аж ахуй тогтвортой хөгжинө. Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжилд эдийн засгийн дэд системийн хөгжил 28.3 хувь, нөөцийн дэд систем 46.5 хувь, байгаль орчны дэд систем 19.1 хувь нөлөөлнө. Нийгмийн дэд системийн хөгжилд эдийн засгийн дэд систем 34.4 хувь, нөөцийн дэд систем 20.2 хувь нөлөөлнө. Мал аж ахуй, газар тариалан нь хөдөө аж ахуйн хоёр үндсэн салбар юм. Эдгээр салбарын үйлдвэрлэлийн үндсэн нөөц нь бэлчээр, тариалангийн газар юм. 2019 оны байдлаар бэлчээр, хадлангийн газрын нийт хэмжээ 112 сая га, тариалангийн газрын нийт хэмжээ 1.12 сая га байна. Эдгээр нөөцийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх боломж байхгүй боловч атаршсан 216.6 мянган га-г ашиглах боломжтой юм. Харин шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт ололтыг тууштай нэвтрүүлж эдгээр нөөцийн үржил шимийг



нь сайжруулан биологийн чадавхад нь нийцүүлэн ашигласнаар хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Эдгээр шаардлагад нийцүүлэн хөдөө аж ахуйн урт хугацааны тогтвортой хөгжлийн ерөнхий хандлагыг тодорхойлсон билээ.

Монголын ХАА-н салбарын нэг онцлог нь байгалийн задгай орчинд явагдах биологийн үйлдвэрлэл юм. Иймд ХАА салбарын хөгжилд байгаль, цаг уур хүчтэй нөлөөлнө. Байгаль, цаг уурыг удирдан жолоодох боломжгүй боловч түүнд дасан зохицох шаардлагатай. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ногоон эдийн засгийн зарчмыг баримтлан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх, даатгал бүртгэл, мэдээлэлд суурилсан ухаалаг систем хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

1960-аад он хүртэл Монгол улс мал аж ахуйн орон байлаа. Өвөг дээдэс маань олон зууны турш мал сүргээ маллан байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицож амьдрах нүүдлийн соёл иргэншлийг бий болгожээ. Нийгэм, эдийн засгийн хөгжил, дэлхийн ХАА-н хөгжлийн дагуу сүүлийн жилүүдэд мал аж ахуйн нүүдлийн сонгодог хэв шинж ихээхэн өөрчлөгдөж байна. Газар тариалангийн салбарын хөгжлийн дагуу байран маллагаа зонхилсон өндөр ашиг шимтэй мал, амьтны аж ахуй хөгжиж байна.

Газар тариалан 1960-аад оноос эхлэн хөгжиж байна. Төр засаг энэ салбарыг хөгжүүлэх атар газар эзэмших I-III аян хэмээх бодлогыг тууштай хэрэгжүүлсний дүнд газар тариалан ХАА-н чухал салбар болон хөгжиж байгаа билээ.

Ажил эрхлэлтэд ХАА-н салбар чухал суурь эзэлнэ. 2019 оны байдлаар нийт өрхийн 26.4 хувь, ажиллагчдын 24.6 хувь ХАА салбарт ажиллаж байна. ХАА салбарын нийт өрхийн тоо 206.1 мянга, үүний 188.6 мянга МАА-д, 17.5 мянга газар тариаланд, нийт 277.8 мянган хүн байна.



Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанарт шилжинэ.



Хүснэгт 3. Хөдөө аж ахуйн салбарын жилийн дундаж өсөлт, хувиар

Он	Мал аж ахуй	Газар тариалан	Хөдөө аж ахуй
2020-2030	1.5%	5.0%	2.0%
2030-2040	2.0%	4.1%	2.4%
2040-2050	2.9%	3.3%	3.0%
2019-2050	2.3%	4.1%	2.6%

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019

Монгол Улсын мал аж ахуй хүнсний болон арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бололцоо өндөртэй салбар. Техник, технологийг сайжруулж, дэд бүтцийг бий болгох замаар таатай орчин бүрдүүлж, боловсруулах үйлдвэрлэлтэй уялдуулан, хяналтын тогтолцоог бүрдүүлснээр бүтээгдэхүүний нэмүү өртөг, чанар сайжирч, экспорт нэмэгдэнэ.

МАЛ АЖ АХУЙ

Мал аж ахуй бол хүн ам, хүнс, хөнгөн үйлдвэрийг мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн ноос, ноолуур, арьс ширээр хангадаг чухал салбар. Нийт малын тоо 1990 онд 25.9 сая байсан бол тогтвортой өсөж 2019 онд оргил үе 70.97 саяд хүрсэн. Нийт малд адуу 5.9 хувь, үхэр 6.7 хувь, тэмээ 0.7 хувь, хонь 45.5 хувь, ямаа 41.2 хувь эзэлдэг. Бэлчээр, хадлангийн талбай 2019 онд 1990 онтой харьцуулахад 7.3 хувь буурчээ. Малын тооны өсөлт, бэлчээр, хадлангийн талбайн бууралтаас шалтгаалж бэлчээрийн ачаалал ихээхэн нэмэгдсэн. Тухайлбал, 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1990 онд 46 байсан бол 2019 онд 106 болж 2.3 дахин нэмэгджээ. Энэ нь бэлчээрийг талхлан доройтуулах, малын биеийн өсөлт, ашиг шимийг бууруулах нэг шалтгаан болж байна. Бэлчээрийн болон мал зүйч мэргэжилтнүүдийн судалгаагаар 100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо улсын дунджаар 77-оос хэтрэхгүй байвал зохистой. Бэлчээрийн доройтолд малын тооноос гадна дэлхийн дулаарал, хур тунадасны хэмжээ нөлөөлнө. Цаг уурын байгууллагын судалгаагаар сүүлийн 80-аад жилд Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд агаарын дундаж температур 2.4 хэмээр нэмэгдэж жилийн дундаж хур тунадас 8 хувь багассан байна.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах нөхцөлийг бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйд даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, гэнэтийн эрсдэлээс учирч болох эдийн засгийн хохирол, эрсдэлийг бууруулах, салбарын хүний нөөцийн тогтвортой ажиллах мэдлэгээ дээшлүүлэх нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, залгамж халааг бэлтгэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, үйлдвэрлэлээ өргөтгөх, хорших санаачилгыг төрийн бодлогоор дэмжиж, ажлын байрыг тогтвортой хадгалахаар зорьж байна.

Бэлчээрийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх үндэс нь малын тоог бэлчээрийн даацад тохируулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийг сайжруулах, хуваарьтай сэлгэн ашиглах, хадлангийн өвс, нэмэгдэл тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж, малын үүлдрийг сайжруулах зэрэг менежментийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд оршино.



Хүснэгт 4. Бэлчээрийн малын тооны хэтийн хандлага

Он	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Бүгд
2019	3,430,641	4,466,170	22,937,408	19,235,936	410,043	50,480,198
2025	3,407,042	4,435,448	22,779,626	19,103,616	407,222	50,132,954
2030	3,053,157	3,974,744	20,413,538	17,119,350	364,925	44,925,714
2035	3,038,321	3,955,430	20,314,345	17,036,164	363,152	44,707,412
2040	3,081,430	4,011,552	20,602,573	17,277,880	368,304	45,341,739
2045	2,876,045	3,744,172	19,229,359	16,126,266	343,756	42,319,598
2050	2,911,609	3,790,471	19,467,144	16,325,678	348,006	42,842,909

Эдгээр бодлогын зохицуулалтыг үндэслэн тодорхойлсон бэлчээрийн малын тооны урт хугацааны хандлагыг дээрх хүснэгтэд үзүүлэв. Бэлчээрийн даац экологийн бүсүүдээр ялгаатай. Энэ нь малын тоог экологийн таван бүсийн бэлчээрийн даацыг үндэслэн тодорхойлсон улсын хэмжээний үр дүн юм. Бэлчээрийн даацад тохирсон нийт малын дундаж биет тоо 46.3 сая, хонин толгойгоор 85.4 сая байх бөгөөд 100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 77 байх юм.

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019

ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙ

Сүүлийн жилүүдэд малын тоо хэт өсөж бэлчээрийг доройтуулах болсон нэг шалтгаан нь бэлчээрийн монгол малын ашиг шим бага, ноолуураас бусад мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ доогуур байгаатай холбоотой. Бэлчээрийн монгол малаас гадна өндөр ашиг шим бүхий мал, тэжээвэр амьтдыг үржүүлж байж жилээс жилд нэмэгдэж байгаа мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлтийг хангана. Манай улс сүүний Хар тарлан, Монтбелярд, Швейцарын бор, махны Сэлэнгэ, Казахын цагаан толгойт, Герефорд, Ангус, Лимузин, Халимаг үүлдрийн үхэр мөн нарийн, нарийвтар ноост Хангай, Орхон үүлдрийн хонь, сүүний Альпин үүлдрийн ямаа үржүүлж байгаа билээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн өндөр ашиг шимтэй үүлдрийн малаар малын генефондоо өсгөн нэмэгдүүлэхэд анхаарч байна. Эдгээр мал амьтдыг байран болон хагас байран технологиор маллах тул тэжээлийн ургамалын тариалалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болно. Хүснэгтэд өндөр ашиг шимт үүлдрийн мал амьтадын тоо болон үндсэн ашиг шимийн хэтийн хандлагыг үзүүллээ. Эрчимжсэн мал амьтны үндсэн ашиг шимээс гадна үндсэн бус ашиг шимийг хүртэнэ. Мал, амьтны маллагаа, үржлийн ажлын технологийг нарийн мөрдөж байж үүлдрийн чадавхыг бүрэн ашиглах боломж бүрдэнэ.

Монгол Улс олон улсын шаардлага хангасан шүлхийн хяналтын аргачлал хэрэгжүүлж, баталгаажуулсны дараа импортлогч оронтойгоо харилцах шаардлагатай. Боловсруулах үйлдвэрүүд тус бүрдээ ийм арга хэмжээг авч хэрэгжүүлэх зүйтэй.

Хязгаарлагдмал орон зайд буюу газар, бэлчээрийн давчуу нөхцөл байдалд малыг сайжруулсан орчинд эрүүл байх нөхцөлийг бүрдүүлж, идэш тэжээл, ус, эм бэлдмэл болон шинжлэх ухаан, технологийг бусад хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, химийн бодисыг түлхүү ашиглагдагараа эрчимжсэн мал ахуй онцлогтой. Малын үүлдэр угсаа, үржил селекцийн асуудалд хянуур хандах, орчин нөхцөлийн стандартыг хангах, бохирдол, эрүүл ахуйн асуудалд анхаарч ажиллах шаардлагатай.

Гэтэл мал, амьтны ашиг шимийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал, ҮСХ-ны 2015 оны түүвэр судалгаагаар сүүний цэвэр үүлдрийн үнээний жилийн саалинд хамрагдах дундаж хугацаа 305 хоног байх ёстой атал есөн сар нэг үнээний жилийн дундаж саам 1,146.1 литр, нутгийн монгол үнээний саалинд хамрагдах хугацаа 5.9 сар, нэг үнээний дундаж саам 374.5 литр байна. Энэ баримт мал аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийг дээшлүүлэх ихээхэн боломжийг алдаж байгааг харуулж байна. Мал, амьтны маллагаа, тэжээллэг, үржил селекц, эрүүл мэндийг сайжруулж байж ашиг шимийг нь бүрэн ашиглана.

МАА, газар тариалангийн салбарын урт хугацааны хөгжлийн нэгдсэн үзүүлэлтийг хэсэгчлэн хүснэгтээр үзүүлэв. Хэтийн хандлагын тооцоог өмнөх 18 жилийн динамикийг үндэслэн тохиолдож болох эрсдэл, өөрчлөлтийг тооцон SIMTOOLS аргыг ашиглан гүйцэтгэв. Бүтээгдэхүүний үнийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр илэрхийлсэн тул өсөлтийн өртгийн үзүүлэлт нь тухайн салбарын бүтээгдэхүүний биет өсөлтийг илэрхийлнэ. МАА, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийн бүтэц 2019 онд 87.2 хувь, 12.8 хувь байсан бол 2050 онд 79.1 хувь, 20.9 хувь болох төлөвтэй юм. Монгол Улсын шинжлэх ухааны салбарт тэргүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлд нэвтэрсэн, нэвтрүүлэн ололт амжилтаараа ч манлайлдаг.

Хүснэгт 5. Эрчимжсэн малын үзүүлэлт

Он	Сүүний үхэр		Махны үхэр		Ноосны хонь		Сүүний ямаа	
	үхэр тоо	сүү мян литр	үхэр тоо	мах тонн	хонь тоо	ноос тонн	ямаа тоо	сүү мян литр
2019	113,898	61,844	32,394	1,756	2,151,439	7,491	234,234	8,780
2025	181,043	161,840	45,831	2,478	2,478,014	8,628	259,846	9,741
2030	272,979	293,002	61,141	3,305	2,787,208	9,704	283,333	10,622
2035	411,668	514,289	81,565	4,409	3,134,981	10,915	308,944	11,582
2040	620,819	884,821	108,812	5,882	3,526,147	12,277	336,870	12,629
2045	936,230	1,472,093	145,161	7,847	3,966,120	13,809	367,320	13,770
2050	1,411,888	2,222,533	193,651	10,468	4,460,991	15,532	400,522	15,015

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019



МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН, СҮҮ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Чиглэл чиглэлээрээ мал аж ахуй, мал эмнэлэг, ургамал хамгаалал, ургамал газар тариалангийн чиглэлээр бие даан хөгжсөн нь үүний илэрхийлэл. Зөвхөн мал эмнэлгийн чиглэлийн эрдэмтэд дөрвөн олон улсын патентын эрхийн хамгаалалт эзэмшиж, дотоодын патент 80 гаруйг баталгаажуулсаны зэрэгцээ дэлхийн шинжлэх ухаанд дөрвөн том нээлт бүртгүүлж, малын эмчилгээний вакцин, оношлуур 64-ийг, эм био бэлдмэл 72-ыг боловсруулж, үндсэндээ 200 гаруй үндэсний технологи бүхий мал, төлийн өвчин оношлох, эмчлэх, тэдгээрээс сэргийлэх вакцин эм, био бэлдмэлийг зохион бүтээн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдаг. Мөн мал аж ахуйн эрдэмтэд арвин ашиг шимт 38 үүлдэр, есөн омог, тэжээлийн 10 гаруй төрлийн омог, 96 сортын үр тариаг гаргаж авч, 20 гаруй сортыг нутагшуулаад зогсохгүй Монгол Улсын нутаг дэвсгэрийн экосистемийг хадгалан хамгаалах, ургамал хамгааллын салбарт биобэлдмэл боловсруулж үр дүнтэй ашиглахаас эхлээд жинхэнэ утгаараа бодит үр дүнгээ өгөх эрдэм шинжилгээний бүтээлийг олноор нь үйлдвэрлэлд нэвтрүүлж, туршин хэрэгжүүлсэн түүхтэй. Өөрөөр хэлбэл бэлчээрийн доройтолтой тэмцэх, мал сүргийг эрүүлжүүлэх, шинэ сорт нутагшуулах, экологийн цэвэр бүтээгдэхүүн экспортлох чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд манай эрдэмтэн судлаачид хамтран ажиллах бүрэн боломжтой юм.

Хүн амын мах, махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах боломжтой байна. Махны хангамжийн түвшин буурч байгаа нь бэлчээрийн даацтай уялдан бэлчээрийн малын тоо өсөхгүй байгаатай холбоотой юм. Сүүний үхрийн тооны эрчимтэй өсөлт сүүний хангамжийг ихээхэн нэмэгдүүлж байна.

Ийн уламжлалт нүүдлийн аж ахуйг шинэчлэх хөрс суурь нь энэ салбарт ногоон эдийн засгийн зарчмыг баримтлан, байгальд ээлтэй технологийг нутагшуулах явдал бөгөөд оюуны багтаамж өндөртэй органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр экспортыг нэмэгдүүлэх нь эн тэргүүнд тавигдах зорилго хэмээн тодорхойлсон. Ингэснээр 2050 он гэхэд шинжлэх ухаанд суурилсан ногоон үйлдвэрлэл, бизнес, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг дэмжиж, биотехнологийн үйлдвэрлэлийг өргөжүүлж, органик брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эдийн засгийн орлогын шинэ эх үүсвэр болгон баталгаажуулсан байх юм.

Монголын уламжлалт бэлчээрийн мал ах ахуйн ашиг шимийн үйлдвэрлэл нь улирлын чанартайгаараа онцлог. Тарга тэвээргээс хамааран мах бэлтгэл намрын улиралд хийгддэг бол сүүний үйлдвэрлэл зуны улиралд, ноос, ноолуур хяргах, самнах ажил хавар явагддаг. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мал аж ахуйн салбарыг хөгжүүлж, улирлын хамаарлыг багасгаснаар үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх боломжтой.

Ноос, ноолуур болон мал аж ахуйн бусад түүхий эд нь жил бүр нөхөн сэргээгдэж байдаг шавхагдашгүй үнэт баялаг юм.

НООС, НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН

Мал аж ахуйн салбарт ирээдүйд бэлчээрийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урсгалыг бий болгож үнэ цэнийн сүлжээг хөгжүүлсэн, тогтвортой үйлдвэрлэлийг явуулахад бодлого чиглэгдэнэ гэж төлөвлөсөн.

- Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл одоогийн түвшнээс буурахгүй ба жилд ойролцоогоор 0.5 хувиар нэмэгдэж 2030 оны түвшинд 22.0 орчим хувьд хүрнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлд оруулах нийт хөрөнгө оруулалтын хэмжээ одоогийн түвшнээс 40 орчим хувиар нэмэгдэх ба үндсэн хөрөнгийн жилийн дундаж өсөлт 5.0 хувьд хүрч, ашгийн дундаж түвшин 20-25.0 орчим хувьд хүргэнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэлд мэдлэгийг хэрэглээ болгох чадамжийг бүрдүүлж, судалгаа ба хөгжлийг өргөжүүлснээр “органик үйлдвэрлэл эрхлэгч” болох өрсөлдөөн, урсгал тэлэгдэнэ.
- Малын биологийн нөөцийг бүрэн ашиглахад суурилсан биотехнологийн үйлдвэрлэл өргөжиж, улс орны эдийн засгийн орлогын шинэ эх үүсвэрийг бүрдүүлж эхэлнэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөр хөнгөлөлт, техникийн шинэчлэл одоогийн түвшнээс 30 хүртэл хувиар нэмэгдэнэ.
- Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах систем төлөвшиж, олон улсад IPO гаргана.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх ажлын байр төдийлөн буурахгүй хадгалагдах ба хот суурингийн төвлөрөлтөөс зайлсхийж, нийгмийн ая тухтай байдлаа сайжруулан хөдөөд ажиллах сонирхлын нөхцөл бүрдэж, зорилтот зах зээлд чиглэсэн, үр ашигтай “ухаалаг” аж ахуй эрхлэх загварт шилжинэ.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газар зүйн болон бусад мэдээллийн системийг бүрэн ашиглан холбогдох мэдээллийг өөрсдөө улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд дамжуулах чадавхтай болж, маркетингийн сүлжээний хөгжил, үр ашиг, бүтээмжээр өрсөлдөх болно.
- Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, тэмцэх, зооноз, халдварт зарим өвчнөөс мал сүргийг бүрэн эрүүлжүүлж, гадаад, дотоод зах зээлд малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүсчлэн бүрдүүлнэ.
- Стратегийн ач холбогдлыг харгалзан мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох систем тодорхой хэмжээнд хадгалагдана.



ГАЗАР ТАРИАЛАН

1990 оны нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн жилүүдэд газар тариалангийн салбар гүнзгий уналтад орсон билээ. Тариаланчдын хүчин чармайлт, төрийн дэмжлэгийн үр дүнд 2008 оноос тус салбар сэргэн хөгжиж байна. Газар тариаланг сэргээн хөгжүүлэх “Атар III” төрийн бодлого хэрэгжсэний үр дүнд 2019 гэхэд дотоодын үйлдвэрлэлээр буудай, төмсний дотоодын хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүрээд байна. Гэсэн хэдий ч бусад үр тариа, хүнсний ногоо, тосны ба техникийн ургамал, малын тэжээл, жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг тогтвортой нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Тариаланд тохиромжтой газрыг бүрэн ашиглах, хөрсний үржил шимийг сайжруулах, элит болон нутагшсан сортын үрийн тариалалтыг нэмэгдүүлэх, усалгаатай тариаланг хөгжүүлэх зэрэг бодлогыг хэрэгжүүлсний дүнд таримлуудын нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх боломжийг үндэслэн газар тариалангийн урт хугацааны хөгжлийн хандлагыг тодорхойлов.

Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж, мал аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллаж байгаа иргэдийг дэмжих, орон нутагт бизнес эрхлэх орчныг сайжруулах нь бүсчилсэн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх нэг чухал хүчин зүйл байх болно.

Хүснэгт 6. Тариалангийн газар ашиглалтын хэтийн хандлага, мян га

Он	Эргэлтийн талбай	Буудай	Бусад үр тариа	Тосны ба техникийн	Малын тэжээл	Буурцаг таримал	Төмс	Хүнсний ногоо	Эмийн ба бусад	Жимс жимсгэнэ	Нийт тариалалт	Уринш талбай
2019	888.1	367.7	24.2	72.4	47.2	1.9	13.5	8.8	0.7	6.8	536.4	351.7
2025	919.4	376.3	34.8	80.3	70.4	9.1	15.5	15.1	1.1	13.4	602.6	316.8
2030	947.2	400.7	45.2	86.9	103.3	14.4	16.8	17.6	1.2	16.8	686.1	261.1
2035	1,030.9	438.1	60.9	97.5	154.3	23.6	18.8	21	1.5	21.7	815.7	215.2
2040	1,121.9	466.7	80	106.6	176.1	37.6	20.6	21.3	1.7	24.4	910.6	211.3
2045	1,233.0	486.3	116.6	113.5	213.9	71.5	21.9	21	1.9	25.1	1,046.6	186.4
2050	1,295.5	498.7	161.6	120	257.6	90.1	23.2	22.1	2.1	26.3	1,175.4	120.1

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019

Хүснэгт 7. Хураах ургацын хандлага, мян тонн

Он	Буудай	Бусад үр тариа	Тосны ба техникийн	Малын тэжээл	Буурцаг таримал	Төмс	Хүнсний ногоо	Жимс, жимсгэнэ
2019	478.0	31.0	36.9	143.0	2.3	166.2	109.8	3.8
2025	613.4	56.0	42.6	226.0	13.1	210.6	209.3	8.0
2030	713.2	79.1	47.8	304.7	22.9	232.7	261.0	11.3
2035	863.1	118.8	61.4	507.6	39.9	278.8	330.8	15.6
2040	938.1	159.2	77.8	618.1	68.8	325.1	365.3	18.3
2045	962.9	227.4	91.9	800.0	142.3	367.7	386.6	20.3
2050	1,032.3	331.3	97.2	973.7	194.6	435.9	437.1	22.9

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019

Энэ нь МАА, газар тариалангийн салбарын өсөлттэй холбоотой болохыг хүснэгтээр харуулж байна. Энэ нь бэлчээрийн даацад тохирох бэлчээрийн малын тооны хязгаарлалт, нийт малд эрчимжсэн мал аж ахуйн эзлэх хэмжээ бага, газар тариалангийн салбарын атаршсан газрыг эргэлтэнд оруулан ашиглаж таримлын талбайг нэмэгдүүлэх, таримлын нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх боломжыг ашигласантай холбоотой юм.

Хүснэгт 8. Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл болон нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлт

Он	ДНБ-нд ХАА-н салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь			ДНБ-нд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь		
	Мал аж ахуй	Газар тариалан	Хөдөө аж ахуй	Мал аж ахуй	Газар тариалан	Хөдөө аж ахуй
2019	17.9%	2.6%	20.6%	12.0%	1.8%	13.7%
2025	16.0%	2.7%	18.6%	10.6%	1.8%	12.4%
2030	11.7%	2.4%	14.1%	7.8%	1.6%	9.4%
2035	9.4%	2.3%	11.7%	6.3%	1.5%	7.8%
2040	8.0%	2.0%	10.0%	5.3%	1.3%	6.7%
2045	6.6%	1.8%	8.4%	4.4%	1.2%	5.6%
2050	5.9%	1.6%	7.5%	4.0%	1.0%	5.0%

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019

Хүснэгт 9. ХАА бүтээгдэхүүний нэг хүнд ногдох үзүүлэлт

Он	Нэг хүнд ногдох орлого, мян.төг*			Нэг хүнд ногдох орлогын өсөлт, хувиар		
	МАА	ГТ	ХАА	МАА	ГТ	ХАА
2019	1,542.5	227.3	1,769.8			
2025	1,747.1	290.6	2,037.8	12.5%	24.6%	14.1%
2030	1,587.0	326.2	1,913.2	2.8%	36.1%	7.8%
2035	1,587.0	390.4	1,977.4	2.8%	54.1%	11.1%
2040	1,666.7	421.4	2,088.2	7.7%	61.7%	16.5%
2045	1,701.6	456.3	2,157.8	9.8%	69.7%	19.8%
2050	1,889.0	499.0	2,388.0	20.3%	78.6%	30.0%

Эх сурвалж: Б.Пүрэв, 2019



Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл болон нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хэмжээний динамикийг харууллаа. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2019 онд 13.7 хувь байсан бол 2050 онд гэхэд 5 хувь болж буурах хандлагатай байна. Энэ нь дэлхийн улс орнуудын хөгжлийн нийтлэг хандлага юм.

Хөдөө аж ахуйн салбарын нэг хүнд ногдох орлого 2019 онтой харьцуулхад 2050 онд 30 хувь өсөх бөгөөд энэ өсөлт мал аж ахуй, газар тариалангийн салбарын хувьд ялгаатай байна. Тухайлбал мал аж ахуйн салбарын өсөлт 20.3 хувь байх бол газар тариалангийнх өндөр 78.6 хувь байх төлөвтэй байна.

Хүснэгт 10. Жишсэн нэг хүнд ногдох газар тариалангийн бүтээгдэхүүн, кг

Он	Буудай	Гурил	Бусад үр тариа	Буурцагт таримал	Төмс	Хүнсний ногоо	Жимс, жимсгэнэ
Жилийн хэрэгцээ, кг		36.5		14.6	43.8	94.9	73
2019	183.2	87.5	11.9	0.9	63.7	42.1	1.5
2020	209.4	100.1	14.9	1.2	66.7	45.3	1.6
2025	211.2	100.9	19.3	4.5	72.5	72.1	2.8
2030	227.7	108.8	25.2	7.3	74.3	83.3	3.6
2035	256.3	122.4	35.3	11.8	82.8	98.2	4.6
2040	257.3	122.9	43.7	18.9	89.2	100.2	5
2045	242.3	115.8	57.2	35.8	92.5	100.7	5.1
2050	238.8	114.1	76.6	45	100.8	101.1	5.3


Эх сурвалж: Б.Пүрэв, 2019

Газар тариалангийн салбарын хөгжлийн үр дүнд хүн амын хүнсний хангамж хэрхэн нэмэгдэхийг харууллаа. Буудай болон гурил, төмсний хэрэгцээг суурь үе 2019 онд бүрэн хангасан. Буурцагт таримлын хэрэгцээг 2038 оноос, хүнсний ногооны хэрэгцээг 2034 оноос бүрэн хангах боломж бүрдэнэ. Харин жимс жимсгэнийн хангамж импортоос хамаарах хандлагатай байна.

Улс орны хүнсний аюулгүй байдал хүнсний хангамж, хүнсний эрүүл ахуй гэсэн хоёр агуулгаас бүрдэнэ. Мал аж ахуй, газар тариалангийн салбар хүн амыг эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан хүнсээр хангах ёстойг анхаарвал зохино. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд зөвхөн хөдөө аж ахуйн төдийгүй хүнсний үйлдвэрлэл, мэргэжлийн хяналтын байгууллагын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй.


Эдгээр судалгаа, тооцоо, бүс, орон нутгийн онцлог, нөхцөл байдалд үндэслэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд тохиромжтой бүсийн зургийг нэгтгэн харуулав.

Зураг 22. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс



Монгол Улс дэлхийн махны зах зээлд “Эко мах” шошгоор байр суурь эзлэх боломжтой. Монгол мал байгальд бэлчээрлэн өвсөөр тэжээгддэг бөгөөд химийн хольцтой тэжээл хэрэглэдэггүй. Хахир хатуу, урт өвлийг сүргийн зөвхөн эрүүл чийрэг хэсэг нь даван туулдаг. Эдгээр үндэслэл нь цаашид нэмүү өртөг шингэсэн мах экспортлох худалдааны хэлэлцээр болон маркетингт сайнаар нөлөөлнө. (United Nations Conference on Trade and Development, 2021)


Зураг 23. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс



Монгол Улсын хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний 204 үйлдвэр, цех 77 хөргөлтийн төв үйл ажиллагаа явуулж, тэдгээрт нийт 1,680 гаруй хүн ажиллаж байна. Сүүний боловсруулах салбарын суурилагдсан хүчин чадал жилд 470.5 мянган тн бөгөөд өнөөдрийн байдлаар 35 хувийг ашиглаж байна. (Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, 2022)




Зураг 24. Ноос, ноосон бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс




Ноосны салбарт өнөөдрийн байдлаар хивсний хоёр, нэхэх дөрөв, ээрэх ес, нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх нэг, угаах 25, хялгас ялгах 23, сүлжих 56, эсгий эдлэл үйлдвэрлэх 16, ноосон бордоо үйлдвэрлэх нэг, эсгийлэх 12, нийт 257 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. (Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, 2022)

Зураг 25. Үр тариа боловсруулах үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс



Газар тариалангийн үйлдвэрлэлийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, экологид ээлтэй, бүтээмж өндөр, эрсдэл даах чадвартай, тогтвортой ургацтай эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн тавьж байна. Зорилтын хүрээнд монгол таримлын өрсөлдөх чадвар, үнэ цэнийг дээшлүүлж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын баримжаатайгаар хөгжүүлнэ. (Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, 2022)

Зураг 26. Арьс ширний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс




Манай улсын арьс, шир боловсруулах үйлдвэрлэлийн салбарт өнөөдрийн байдлаар хагас боловсруулах 14, гүн боловсруулах хуурай цех 4, гүн боловсруулах жижиг үйлдвэр 12, гүн боловсруулах том үйлдвэр 10, завод ноос, ноолуур угаах 6 аж ахуй нэгж, мөн гутлын 32, савхин бээлийний 11, нэхий үслэг эдлэлийн 4, савхин хувцасны 13, савхин цүнх, жижиг эдлэлийн 19 үйлдвэр ажиллаж байна.

Боловсруулах үйлдвэрүүд 18.1 сая ширхэг арьс, ширийг хагас боловсруулах, 2.5 сая ширхэг арьс, ширийг гүн боловсруулах суурилагдсан хүчин чадалтай боловч хагас боловсруулах хүчин чадлын 33.8, гүн боловсруулах хүчин чадлын 68.6 хувийг тус тус ашиглаж байна. (Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, 2022)



Зураг 27. Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс



Эх сурвалж: Үндэсний Хөгжлийн Газар, 2020

Дэлхийн нийт ноолуурын нөөцийн 40 хувийг Монгол, 48 хувийг Хятад, 12 хувийг Иран, Афганистан зэрэг улсууд бэлтгэдэг. Өнөөдрийн байдлаар ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 үйл ажиллагаа явуулж, угаасан ноолуурыг Хятад, самнасан ноолуурыг Хятад, Итали, Англи, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Бельги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолж байна. (Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, 2022)

ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Их Хурал. (2001). "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 2001 оны 57 дугаар тогтоол. УБ.
- Монгол Улсын Засгийн газар. (2021). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга. УБ.
- Байгаль орчин, Аялал жуулчлалын яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.
- Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА). (2021). Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл (Эцсийн тайлангийн төсөл 3). УБ.
- Б.Пүрэв. (2019). Хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн хэтийн тооцоо. УБ.
- Зам, Тээврийн хөгжлийн Яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.
- Монголын Эдийн засгийн Форум. (2022). Илтгэл танилцуулга. УБ.
- Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага. (2022). Шилжих хөдөлгөөний бодлогын судалгаа. УБ.
- Р.Ринчинбазар; Д.Эрдэнэбаяр. (2019). Бүс нутгийн шинжлэх ухааны үндэс. УБ.
- Үндэсний Хөгжлийн Газар. (2020). Салбарын танилцуулга. УБ.
- Үндэсний хөгжлийн газар. (2021). Орон нутгийн хөгжлийн үзүүлэлт, 21 аймгаар (2020). <https://www.ldi.nda.gov.mn/>
- Үндэсний Статистикийн Хороо. (2022). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn>
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Сүү үйлдвэрлэлийн салбарын танилцуулга. <https://mofa.gov.mn/exp/blog/10/80>
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Монголын ноос боловсруулах үйлдвэрийн салбарын танилцуулга-2020. <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/noos2020.pdf>
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Газар тариалангийн салбарын бодлого. <https://mofa.gov.mn/exp/blog/8/245>
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын танилцуулга. <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/arisshir2020.pdf>
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Монголын ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарын танилцуулга-2020. <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/nooluur2020.pdf>
- Эдийн засаг, Хөгжлийн яам. (2022). Монгол Улсын эдийн засгийн микро бүсийн төсөл. УБ.
- United Nations Conference on Trade and Development. (2021). Fostering Integration of the Mongolia Downstream Value Chain of Meat into Regional Value Chains. https://unctad.org/system/files/information-document/THAN_MON_Market_Research_Perez_Boldbaatar_Mon_version_29Jan21.pdf

ТОВЧИЛСОН ҮГСНИЙ ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГТ	Газар тариалан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МАА	Мал аж ахуй
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй